



“Өсвөрийн аврагч” бүлгийн чиглүүлэгч багшийн гарын авлага

СОЁМБО нь тусгаар тогтносон, бүрэн эрхт, эртний түүх, соёл, төр ёсны арвин баялаг уламжлал бүхий эх оронч Монгол хүнийг илэрхийлнэ.

ТАВАН ХОШУУ нь тангараг өргөсөн аврагчийг илэрхийлнэ.

ГУРВАЛЖИН нь иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдэг, гурван өнгийн гар нь эв нэгдэл, хамтын ажиллагааг илэрхийлнэ.

НОМ нь Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсрол гэсэн утга санааг илэрхийлнэ.

ЭМЖСЭН ЧИДҮН ЖИМСНИЙ МӨЧИР нь ялалт, амжилтыг бэлгэдэх ба мөнхөд оршихуйн утга санааг илэрхийлнэ.

ӨНГӨ нь гал, ус, эх дэлхийг бэлгэднэ.



“Өсвөрийн аврагч” бүлгийн чиглүүлэгч багшийн гарын авлага

Эмхэтгэн бэлтгэсэн:	Д. Сэржмядаг (PhD) Гамшиг судлалын хүрээлэн Проф. Ц. Хонгорзул (PhD) МУБИСургууль	
Хянан тохиолдуулсан:	Б. Ванчиндорж Н. Өлзиймаа Г. Дашдорж	Дэлхийн Зөн Монгол ОУБ Дэлхийн Зөн Монгол ОУБ Дэлхийн Зөн Монгол ОУБ
Номын дизайныг:	Т. Норов З. Цэрэндагва	

Ашгийн зорилгоор хуулбарлан олшруулахыг хориглоно.

ISBN - 978-99973-2-924-0



USAID
FROM THE AMERICAN PEOPLE

World Vision
Дэлхийн Зөн Монгол

“ӨСВӨРИЙН АВРАГЧ” БҮЛГИЙН
ЧИГЛҮҮЛЭГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР / ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОУБ

Улаанбаатар хот - 2015



АГУУЛГА



Өмнөх үг	6	Дөрөвдүгээр бүлэг. Өсвөрийн аврагч бүлэгт гамшгаас хамгаалах боловсрол	
Номын хөтөч	7	олгох үйл ажиллагаа: Ахисан түвшин	
Нэгдүгээр бүлэг. Хүүхдийн бүлгийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулах нь		4.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	38
1.1. Хүүхдийн бүлгийн чиглүүлэгчийн үүрэг	8	4.2. Гамшгийн эрсдэлийн тухай	40
1.2. Идэвхжүүлэх ба чиглүүлэх нь	9	4.3. Нэрвэгдэгсдийг аврах тусламж үзүүлэх, зөөх ажиллагаа	40
Хоёрдугаар бүлэг. Өсвөрийн аврагч бүлгийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	11	4.4. Өрхийн бэлэн байдлын багц	
2.1. Өсвөрийн аврагч бүлгийн сургалтын жишиг төлөвлөгөө	14	4.5. Онцгой байдлын алба	
2.2. Өсвөрийн аврагч бүлгийн сургалтын жишиг хөтөлбөр	16	4.6. Аврагч, гал сөнөөгч мэргэжил	42
Гуравдугаар бүлэг. Өсвөрийн аврагч бүлэгт гамшгаас хамгаалах боловсрол олгох үйл ажиллагаа: Анхан түвшин	17	4.7. Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуурыг ашиглах арга	43
3.1. Гамшгийн тухай ойлголт	20	4.8. Гал түймрийн үед амь насаа хамгаалах арга, түлэгдэлтэнд үзүүлэх тусламж	44
3.2. Зарлан мэдээллийн дохио	22	4.9. Ой хээрийн түймрийн үед авах арга хэмжээ, унтраах арга	45
3.3. Гал түймэр хэрхэн гардаг вэ?	22	4.10. Зудын эрсдэл, түүнийг бууруулах арга	
3.4. Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга, тэмдэг тэмдэглэгээ	23	4.11. Үерийн аюулаас хэрхэн хамгаалах вэ?	46
3.5. Ой, хээрийн түймэр, түүнээс сэргийлэх арга	25	4.12. Гол мөрний усны осол, тусламж үзүүлэх арга	47
3.6. Хүчтэй салхи, шуурганаас хамгаалах арга	26	4.13. Химийн хортой болон аюултай бодисын аюулаас хамгаалах арга	48
3.7. Аянга, цахилгаанаас хамгаалах арга	27	4.14. Төөрсөн үед өөрийгөө аврах арга	49
3.8. Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах арга	29	4.15. Тэсэж амьд үлдэх арга	50
3.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах	31	Ашигласан материал	50
3.10. Гамшгийн үе дэх хүүхэд хамгаалал	32		52
	33		53
	35		56



ӨМНӨХ ҮГ

Гамшгаас хамгаалах талаар мэдлэгтэй болох нь танд, танай гэр бүлд тэр тусмаа хүүхэд бүрийн өдөр тутмын амьдралд нэн хэрэгтэй зүйл гэдэгтэй таныг санал нэгдэж байгаад бид баяртай байна.

Гамшгаас хамгаалах, эрсдэлгүй аж төрөх боловсрол эзэмших нь хүний амьдрах явах, аюулгүй орчинд амьдрах язгуур эрх ашгаар илэрхийлэгдэнэ. Монгол Улсын Үндсэн хуулинд “Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй” хэмээн тунхагласан байдаг. Ийм ч учраас манай улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд баталсан хүний эрхийг тодруулбал хүүхдийн эрхийг дээдлэх, аюулгүй орчныг бий болгох, гамшгаас хамгаалахтай холбоотой олон улсын гэрээ, конвенц, бодлогын баримт бичигт нэгдэн орж энэ талаар олон улсад үүрэг хүлээдэг. Тэдгээрийн нэг нь Хүүхдийн эрхийн конвенци бөгөөд тус баримт бичигт хүүхдийн эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг:

- 13-р зүйл: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
- 15-р зүйл: Эвсэн нэгдэх;
- 29-р зүйл: Хүний эрх ба ардчиллыг хүндэтгэх нөхцөлийг хангахуйц боловсрол олж авах

зэрэг эрхээр баталгаажуулсан байдаг.

Монгол Улсын “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичигт “...хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах..” гэж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Гамшгаас хамгаалах сургалтыг удирдах албан тушаалтны; аврах анги, отряд, салбар, мэргэжлийн ангийн; оюутан, сурагчдын; ажилтны; бусад иргэний гэсэн ангиллаар явуулна” гэж заажээ. Иймд Өсвөрийн аврагч бүлэг нь хүүхдийн эвсэн нэгдэх, сурч боловсрох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан, хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажил юм.

Өсвөрийн аврагч бүлэг нь сурагчдын сайн дурын үүсгэл санаачлагад тулгуурлан байгуулагдсан өөрөө удирдах байгууллага боловч үйл ажиллагааг нь чиглүүлэгч, удирдагч том хүн байх зайлшгүй шаардлагатай. Гамшгаас хамгаалах асуудал их өргөн хүрээг хамрах тул хүүхдийн бүлгийг чиглүүлэгч багш та зарим тохиолдолд биологи, хими, эрүүл мэнд, нийгмийн ухаан, биеийн тамир, газарзүйн хичээлийн багш нар болон эмч, эмнэлгийн ажилтан, цагдаа, малын эмч, онцгой байдлын ажилтан, орон нутгийн түүхийг сайн мэдэх ахмад хүмүүс зэрэг бүлгийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэдлэг туршлагаа хуваалцах хүсэлтэй хэн бүхэнтэй хамтарч ажиллах нь нэн чухал юм шүү. Бүлэг үйл ажиллагаандаа олон төрлийн хүмүүсийг татан оролцуулах нь нэг талаас хүүхдүүдэд сонирхолтой байхын зэрэгцээ ажлынхаа цар хүрээг өргөжүүлэх, нийтэд хүргэхэд тань тус нэмэр болно.





Тус гарын авлага нь хүүхдийн бүлгийн үйл ажиллагааг багш хэрхэн амжилттай чиглүүлэх тухай зөвлөмж хэсэг, сурагчдад гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар, хандлага олгоход чиглэгдсэн агуулга бүхий 2 түвшний сургалтын хөтөлбөр, тус хөтөлбөрийн хүрээнд авч үзэх 25 хичээлийг удирдан чиглүүлэх арга зүйн тайлбар хэсгээс бүрдэнэ.

Хүүхдэд зориулсан гарын авлагад хичээл тус бүрийн онолын мэдлэгийг хүүхдэд ойлгомжтой хэлбэрээр хүргэхээр оруулсан байгаа тул багш та багшийн гарын авлага дахь заах арга зүйн хэсэг болон сурагчийн гарын авлагын онолын хэсгийг уялдуулан бүлгийн гишүүдийн идэвхтэй, бүтээлч хандлагад тулгуурлан эдгээр хичээлийг төвөггүйхэн явуулж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Та бүхэн эдгээр хичээлийг тухайн бүс нутаг, хүүхдийн насны бүлэгт тохируулан хэрэглэвэл илүү тохиромжтой бөгөөд гарын авлагад багтсан хичээлийг заахад танд шинжлэх ухааны нарийн мэдлэг, тусгай мэргэшил шаардлагагүй юм. Харин таны хүсэл, сонирхолдоо хөтлөгдөж хийж буй ажилд бидний бэлтгэсэн гарын авлага тодорхой хэмжээгээр тус нэмэр болно гэдэгт найдаж байна.

Таны ажилд амжилт хүсье.

НОМЫН ХӨТӨЧ

Гарын авлагаа хэрэглэхдээ дараах таних тэмдгүүдийг ашиглаарай.



- Тулгуур ойлголт



- Хичээлийн
хэрэглэгдэхүүн





НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ



1.1 ХҮҮХДИЙН БҮЛГИЙН ЧИГЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ


Хүүхэд бүр өөрийн гэсэн чадвартай, мөн өөрийн чадах зүйлдээ оролцохыг хүсэж байдаг. Гагцхүү зөв дэмжлэг туслалцаа, бас итгэл найдвар хэрэгтэй. Эндээс харахад хүүхдийн оролцоог чиглүүлж байгаа багш нарын хувьд хүүхдүүдэд ямар учраас оролцох, үүнд оролцсоноор ямар үр дүнд хүрэх гээд илүү тодорхой байдлаар хандах хэрэгтэй.

Хүүхдүүд аливаа бүлэгт ямар учраас оролцдог вэ?

- Өөрийгөө таньж мэдэх, үнэлэх
- Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх
- Өөрийнхөө чадах зүйлд оролцох, хөгжих
- Оролцож, хийж байгаа зүйл нь өөрт нь болоод бусад хүмүүст үр дүнгээ өгнө гэдэгт итгэх
- Өөртэй нь хамаатай асуудлаар санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх
- Мэдлэг, мэдээлэл олж авах, түүнийгээ бусадтай хуваалцах
- Өөрийгөө чадваржуулах, бусдаас суралцах
- Найз нөхөд, хамт олонтой байх
- Ямар нэгэн ялгаварлалгүйгээр тэгш оролцох
- Хүүхэд аливаа зүйлд оролцсоныхоо төлөө ямар нэгэн аюул, заналхийлэлд өртөхгүй байх буюу аюулгүй байдлаа мэдрэх
- Нийгэмд идэвхтэй иргэн байж, сайн сайхны төлөө өөрийн хийж чадах зүйлээ хийх

Хүүхдийн бүлгийг чиглүүлэн удирдаж ажиллах хүний хандлага, үнэт зүйл, зан ааш, мэдлэг боловсрол ямар байх нь их чухал. Үүнийг хүний биеийн зураглалаар дүрслэн тайлбарлая.

- Хандлага буюу үнэт зүйл - Зүрх
- Мэдлэг боловсрол - Толгой
- Туршлага - Гар хөл





Сайн чиглүүлэгч байхын тулд танд шаардлагатай мэдлэг боловсрол:

- Хүүхдийн эрхэд суурилсан арга зүйг сайн мэддэг байх
- Хүүхдийн эрхийн талаар болон хүүхдийг оролцуулах талаар мэдлэг туршлагатай байх
- Хүүхдийг зөв шийдвэр гаргахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Ялгаатай байдлыг анхааран, ялгаварлан гадуурхахгүй байх
- Хүүхдийг багаар ажиллуулах
- Хүүхдүүдийг оролцуулахдаа аюулгүй байдлыг нь хангах
- Хүүхдийг сонсож тэднийг шийдвэр гаргахад нь урамшуулдаг
- Мэдээллийг тодорхой бүтээлч байдлаар хуваалцдаг

Сайн чиглүүлэгчид байхад танд шаардагдах туршлага:

- Хүүхдийн өөрсдийн онцлогт тохируулан төлөвлөгөө гаргаж ажиллах
- Хүүхдийг сонсож, юу хэлэх гээд байгааг нь сайн ойлгох
- Уян хатан байх
- Туйлшрахгүй, тууштай байх
- Хүүхэд бүрт тэгш боломжийг олгох
- Хүүхдүүдтэй ойр харилцаж сайн ажигладаг байх
- Хүүхдүүдийн дунд гарч болох зөрчлийг эергээр шийддэг байх
- Хүүхдүүдийг уриалан дуудах чадвартай байх
- Хүүхдэд итгэл өгдөг
- Хүүхдүүдийнхээ эцэг, эхтэй холбоотой байж мэдээлэл өгч байх
- Хөгжилтэй байх, хүүхэдтэй найз шиг нь харилцах
- Оролцохгүй байгаа хүүхдийг дэмжиж оролцуулах
- Хүүхдүүдийг урамшуулах
- Хүүхдэд үлгэр дууриал үзүүлэх
- Ямар нэг үйл ажиллагааг хөгжилтэй байдлаар зохион байгуулдаг
- Хүүхдүүдийг үзэл бодлоо илэрхийлэхэд нь ялгаварлалгүйгээр бүгдийг нь сонсдог
- Хүүхдүүдийг өөрсдийгөө илэрхийлэхэд нь тэднийг дэмждэг урамшуулдаг
- Алдаа гаргавал өөрийнхөө алдааг дүгнэх чадвартай байх

Та хүүхэдтэй хандах хандлагаа тодорхойлохдоо дараах зүйлийг өөрөөсөө асуугаарай.

		Тийм	Үгүй	Тайлбар
1	Би хүүхдийн эрхэд суурилсан байдлаар ажилдаг			
2	Би хүүхдийн амьдралд эерэг өөрчлөлт гаргахыг хүсдэг			
3	Би хүүхэдтэй ажиллах дуртай			
4	Би хүүхдэд эелдэг зөөлөн, найрсаг хандаж чаддаг			
5	Би хүүхдийг сонсдог			



6	Би хүүхдийг өөрөө шийдвэр гаргахад дэмжиж тусалдаг			
7	Би хүүхдийг бие даахад нь тусалдаг			
8	Би хүүхдийн өөрөө хийж чадах зүйлийг өөрөөр нь хийлгүүлдэг			
9	Би хүүхдэд туслахдаа хэзээд бэлэн байдаг			
10	Хүүхэд аливаа үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэхэд нь тусалдаг			
11	Хүүхдийн өөрсдийн санал санаачлагыг дэмждэг			
12	Би хүүхэдтэй ажиллахдаа хүүхдүүдтэй зөвлөлдөж, мэдээлэл өгч чиглүүлдэг			
13	Би хүүхдүүдэд шинэ мэдээлэл өгч дэлхий ертөнц дээр илүү олон боломж байгааг мэдүүлэхийг хүсдэг			
14	Өөрийн санаачилсан ажлыг хүүхдүүдтэй хуваалцдаг			
15	Би хүүхэд бүрийн онцлогийг хүлээн зөвшөөрч илүү хичээж ажилладаг			

Та хэдэн асуултанд нь “тийм” гэж хариулсан бэ? Бас хэдэн асуултанд нь “үгүй” гэж хариулсан бэ? Аль асуултанд нь хариулахдаа эргэлзсэн бэ? Мэдээж та олонхонд нь “тийм” гэж хариулсан гэдэгт итгэлтэй байна. Харин үгүй гэж хариулсан болон хариулахад эргэлзээтэй байсан асуултынхаа талаар яагаад гэдгийг бодоод үзээрэй.

Чиглүүлэгч багш нар дараах зүйлийг санаж байх нь зүйтэй...

Чиглүүлэгч багш нь хүүхдүүдэд шинэ санаа хэлэхгүй, тэдний өмнөөс асуултанд хариулахгүй. Харин хүүхдүүд санаачилга гаргаж бүлгийн үйл ажиллагаанд оролцоход тэднийг урамшуулж, идэвхжүүлэх үүрэгтэй

Хүүхдүүд зарим үед хэт эмзэг сэдвийг хөндөж ярих үед чиглүүлэгч багш ярилцлагыг зөв удирдан чиглүүлж тэдгээр хүүхдүүдэд хэрэгтэй тусламж өгөхөд бүлэгт туслана.



1.2 ИДЭВХЖҮҮЛЭХ БА ЧИГЛҮҮЛЭХ НЬ

Хүүхдийг оролцуулахад хамгийн чухал нь зөв идэвхжүүлж, зөв чиглүүлэх явдал юм. Хүүхдийн бүлэгтэй ажиллах багш бол багш биш идэвхжүүлэгч, чиглүүлэгч бөгөөд хүүхдүүдийн бодол санааг сонсогч, суралцагч, нэгтгэгч, дүгнэгч гэдгийг ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хүүхдүүдэд заах биш харин хамтран суралцах байр сууринаас хандах нь илүү үр дүнтэй юм.

Түүнчлэн, чиглүүлэхдээ аливааг хэт ихдүүлэхгүй ба хэт багадуулахгүй байх талаар бодох хэрэгтэй. Хэт их ярих эсвэл танилцуулга хэт их сунжруулах, хүүхдүүдэд бодох ба ярилцах орон зай өгөхгүй байхаас болгоомжлоорой.

Нөгөө талаас, хэрэв шинэ үйл ажиллагааг хүүхдүүдэд бага заавартайгаар сайн нягтлахгүйгээр даалгавар болгож өгвөл өмнө хийж байгаагүй үйлдэлд хүүхдүүд





дасахгүй эсвэл бусад хүүхдүүдтэй болон томчуудтай ямар нэгэн байдлаар хамтарч ажиллаж сураагүй хүүхдэд хүндрэлтэй байж болох юм гэдгийг санах хэрэгтэй.

Чиглүүлэгч хүн юуг анхаарах хэрэгтэй вэ?

Хүүхдүүдтэй бүлгээр ажиллах, хэлэлцүүлэг хийх нь өдөр тутмын ажлын нэгээхэн хэсэг нь болдог. Тиймээс хэлэлцүүлэг хийхэд анхаарах зүйлийг санал болгож байна. Үүнд:

- Зааварчилгаа нь сайн ойлгогдсон эсэхийг хянах
- Бүлэгт хуваахдаа тэгш хуваах
- Уйдаж байгаа, анхаарахгүй байгаа хэн нэгэнд нь анхаарал тавих
- Бусад бүлэгт (өөр бүлгүүд байгаа бол бүлгийн ахлагч нартай ярилцан) хэлэлцүүлэг яаж явагдаж байгааг шалгах
- Цагт хяналт тавих
- Дуусгах хамгийн тохиромжтой цагийг тодруулах
- Бусадтайгаа хуваалцаж санал авах боломжийг хамгийн тааламжтай байдлаар зохион байгуулах
- Хүүхдүүдэд бодох, хоорондоо ярилцах цаг, орон зайг өгөх
- Хэлэлцүүлгийг ерөнхийд нь дүгнэх эсвэл хаах
- Хэрэв хэлэлцүүлэг цагаасаа эрт эсвэл оройтож дуусвал яах тухай хэлэлцэн, тохирсон арга хэмжээг авах
- Тэвчээртэй хариуцлагатай байх
- Багийнхандаа зорилгоо байнга сануулж идэвхжүүлж байх
- Зэрэгцэн ярихгүй байх
- Хэн нэгэн голлож гол дүрд тоглох, бусдадаа ярих боломж өгөхгүй байгааг
- Үйл ажиллагааны заавраа хүүхдүүдэд ойлгомжтой хэлбэрээр өгөх
- Хүүхдүүдийг сууж байхад том хүн хажууд нь зогсохгүй байх
- Орчин болон сандал ширээний байрлал нь тохиромжтой байх
- Хүүхдийн өмнөөс хариулахгүй эсвэл өгүүлбэрийг нь дуусгахгүй яаруулахгүй байх
- Хүүхдүүдийг түр зуур ярихаа больсон байхад хэт их ярихгүй байх
- Хүүхдүүд дохио зангаагаар эсвэл зүгээр л байж байгаагаараа ярилцлаганд саад болж байж магадгүй учраас тэднийг ажиглах, өөрийнхөө үйл хөдлөлийг анхаарах
- Таахаасаа өмнө хүүхдүүдээс асуух

Хүүхдүүдийг идэвхжүүлэхдээ бүлгийг яаж хуваахаа бодоорой. Бүлгийг хэтэрхий том тойрог болговол ичсэнээс эсвэл энэхүү аргад дасаагүй зарим хүүхдэд ярилцлаганд оролцох нь хэцүү санагдаж болох юм. Иймд бүлгийг цөөн хүүхэдтэй байхаар хуваавал тэд ичихээ больж ярилцлагад идэвхтэй оролцож болно. Бүлэг бүр дэх хүүхдүүдийн тоо, насны байдал, эрэгтэй эмэгтэй хүүхдүүдийн харьцааг мөн харгалзах хэрэгтэй.



Та хүүхдийн бүлгийг чиглүүлэх гэж байгаа бол дараах зүйлийг хийсэн ба бодсон эсвэл төлөвлөсөн эсэхээ дахин нягтлаарай.

- Төлөвлөгөөгөө сайн гаргасан
- Бичиг хэрэг болоод шаардлагатай эд зүйл бүрэн эсэх
- Тоног төхөөрөмж ашиглах бол ажиллаж байгаа эсэхийг анхаарах
- Сандал, ширээ тань таны хүссэн бүлгийн ажлыг явуулахад тохиромжтой байгаа эсэх
- Таны бүрдүүлсэн орчин хүүхдэд ээлтэй тав тухтай орчин мөн эсэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцох гэж байгаа бол орчин бүрдсэн эсэх, тэдний саналыг сонсох болон оролцуулахад шийдвэр гаргах хэмжээний саналыг авч чадах эсэх
- Арга, аргачлал тань таны бүрдүүлсэн хүүхдэд нийцэж байгаа эсэх
- Хугацаандаа багтаах боломжтой эсэх
- Хүүхдүүдийг жигд оролцуулах ямар боломж байгаа эсэх
- Эрсдэлээ тооцож, тухайн үед зөв шийдвэр гаргах боломжийг тооцох





Өсвөрийн аврагч бүлэг нь анхан ба ахисан түвшний хөтөлбөртэй байна.

2.1. Өсвөрийн аврагч бүлгийн сургалтын жишиг төлөвлөгөө

/Төлөвлөгөөнд хичээлийн сэдвүүдийг анхан түвшин – Т1, ахисан түвшин – Т2 гэж тэмдэглэв/

	I долоо хоног	II долоо хоног	III долоо хоног	IV долоо хоног
I cap		T2:Химийн хортой болон аюултай бодисын аюулаас хамгаалах арга	T1:Хүчтэй салхи, шуурганаас хамгаалах арга	
II cap		T1:Гал түймэр хэрхэн гардаг вэ?		
III cap		T2:Ой хээрийн түймрийн үед авах арга хэмжээ, унтраах арга	T2:Өрхийн бэлэн байдлын багц	T1:Зарлан мэдээллийн дохио
IV cap	T1:Ой, хээрийн түймэр, түүнээс сэргийлэх арга	T2:Үерийн аюулаас хэрхэн хамгаалах вэ?	T2:Гол мөрний усны осол, тусламж үзүүлэх арга	
V cap	T2:Аврагч, гал сөнөөгч мэргэжил	T2:Төөрсөн үед өөрийгөө аврах арга		T1:Аянга, цахилгаанаас хамгаалах арга
VI cap	T1:Гамшгийн үе дэх хүүхэд хамгаалал	T2:Тэсэж амьд үлдэх арга	T2:Онцгой байдлын алба	
VII cap				
VIII cap				
IX cap			T1:Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах арга	T2:Нэрвэгдэгсдийг аврах, тусламж үзүүлэх, зөөх ажиллагаа
X cap	T1:Гамшгийн тухай ойлголт	T2:Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	T2:Гамшгийн эрсдэл	
XI cap	T1: Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга, тэмдэг тэмдэглэгээ	T2:Гал түймрийн үед амьгасаа хамгаалах арга, түлэгдэлтэнд үзүүлэх тусламж	T2:Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуурыг ашиглах арга	
XII cap		T1:Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах	T2:Зудын эрсдэл, түүнийг бууруулах арга	

2.2. Өсвөрийн аврагч бүлгийн сургалтын жишиг хөтөлбөр

Сэдэв	Агуулга			Дадал/хэрэглээ
	Мэдлэг	Чадвар	Чадвар	
T1: Гамшигын тухай ойлголт	<p>Аюул, ослын тухай ойлголт өгөх, ялгааг гаргах</p> <p>Гамшигийн тухай үндсэн ойлголт</p> <p>Гамшигийн ангилал /байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдсэн/ Гамшигийн төрөл /салхи, шуурга, уер, газар хөдлөлт,</p>	<p>Аюул, осол, гамшиг гэсэн нэр томъёоны ялгааг хэлэх</p> <p>Гамшиг нь тэмцэх чадавхаас хэтэрсэн, их хэмжээний хохирол гэдгийг жишээгээр тайлбарлах</p> <p>Гамшигийн ангиллыг мэдэж тус бүрд жишээг хэлэх</p>	<p>Аюул, осол тохиолдох бүрийг гамшиг боллоо гэж үзэхгүй байх</p> <p>Аюул, осол болон гамшиг хоорондын ялгааг тайлбарлан нотлох</p>	<p>Аюул, осол тохиолдох бүрийг гамшиг боллоо гэж үзэхгүй байх</p> <p>Аюул, осол болон гамшиг хоорондын ялгааг тайлбарлан нотлох</p>
T2: Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	<p>Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа /урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох/- ны зорилго, үе шатуудыг мэдэх</p>	<p>Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь ямар арга хэмжээнүүдээс бүрдэхийг хэлж чадах /</p>	<p>Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох дарааллыг бусдад илэрхийлэх</p>	<p>Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох дарааллыг бусдад илэрхийлэх</p>
T2: Нэрвэгдэгсдийг аврах тусламж үзүүлэх, зөөх ажиллагаа	<p>Нэрвэгдэгсдийн амьд байгаа шинж тэмдгийг мэдэх</p> <p>Янз бүрийн нөхцөлд нэрвэгдэгсдийг зөөх ажиллагааг мэдэх</p>	<p>Нэрвэгдэгсдийн амьд байгаа шинж тэмдгийг нэрлэх</p> <p>Нэрвэгдэгсдийг зөөх үед тэднийг дамнуурга дээр хэрхэн байрлуулахыг тайлбарлах</p> <p>Нэрвэгдэгсдийг хэрхэн зөөх аргыг нөхөдтэйгээ хамтарч хийж чадах</p>	<p>Нэрвэгдэгсдийн амьд байгаа шинж тэмдгийг нэрлэх</p> <p>Нэрвэгдэгсдийг зөөх үед тэднийг дамнуурга дээр хэрхэн байрлуулахыг тайлбарлах</p> <p>Нэрвэгдэгсдийг хэрхэн зөөх аргыг нөхөдтэйгээ хамтарч хийж чадах</p>	<p>Аврах ажлын талаар ойлголттой болох</p> <p>Эмнэлгийн тусламжийн ач тусыг мэддэг, шаардлагатай үед анхны тусламж үзүүлэх</p>
T1: Зарлан мэдээллийн дохио	<p>Зарлан мэдээллийг хэрхэн дамжуулдаг, мэдээний дохиог сонсоод ялгаж мэдэх /зарлан мэдээлэх дохионы төрөл бичих/</p> <p>Зарлан мэдээллийн дохио хүлээн авсан тохиолдолд сургууль, гэртээ юу хийх, хэрхэн ажиллахыг мэдэх</p>	<p>Оршин суугаа газрынхаа зарлан мэдээлэх систем мэдэх шаардлагатай тохиолдолд ашиглаж чаддаг болох</p> <p>Гэртээ болон сургууль дээрээ хоргодох газраа мэддэг, нөхөддөө болон гэр бүлийхэндээ хэлж тайлбарладаг байх</p>	<p>Оршин суугаа газрынхаа зарлан мэдээлэх систем мэдэх шаардлагатай тохиолдолд ашиглаж чаддаг байх</p> <p>Радио, телевиз, мэдээллийн хэрэгслийн сэрэмжлүүлэх мэдээллийг ашигладаг байх</p>	<p>Оршин суугаа газрынхаа зарлан мэдээлэх систем мэдэх шаардлагатай тохиолдолд ашиглаж чаддаг байх</p> <p>Радио, телевиз, мэдээллийн хэрэгслийн сэрэмжлүүлэх мэдээллийг ашигладаг байх</p>

Т2:Өрхийн бэлэн байдлын багц	Бэлэн байдлын багцын үүрэг, ач холбогдлыг мэдэх	Бэлэн байдлын багцаа бэлтгэх / Үүнд: 3 хоногийн хоол хүнс, ус, зайгаар ажилладаг зөөврийн радио, гар чийдэн, батарей, анхны тусламжийн цүнх бэлэн мөнгө, чухал бичиг баримтууд, ус нэвтрэггүй савтай чүдэнз, ариун цэврийн хэрэглэл, сонсголын төхөөрөмж, нүдний шил гэх мэт өөрт хэрэгтэй чухал эд зүйлс/	Шаардлагатай үед хэрэглэх өрхийн бэлэн байдлын багц, хүнс болон хэрэгцээт зүйлсийн нөөцтэй болох. Өрхийн бэлэн байдлын багцад орох шаардлагатай зүйлс, тэдгээрийн хэрэгцээг гэрийнхэн, баг, хорооныхондоо тайлбарлах
Т2:Онцгой байдлын алба	Монгол Улсын гамшгаас хамгаалах байгууллагын нэр, харьяаллыг мэдэх Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг болон энэ үйл ажиллагаанд оролцогчдыг мэдэх	Монгол Улсын гамшгаас хамгаалах байгууллагын үйл ажиллагааны ач холбогдлыг тайлбарлах	Гамшгаас хамгаалах байгууллагын онцлогийг мэдэх, тэдний ажлаар бахархах Гамшгаас хамгаалах салбарын үйл ажиллагаа өөрийн амьдарч орон нутагт болон сургууль дээр нь хэрхэн хэрэгжиж байгаад дүгнэлт хийх
Т2:Аврагч, гал сөнөөгч мэргэжил	Аврагч, гал сөнөөгч гэж хэнийг хэлэхийг мэдэх	Аврагч, гал сөнөөгчийн мэргэжлийн онцлогийг хэлэх, ялгааг дурдах	Аврагч, гал сөнөөгч мэргэжлийг сонгох хүсэл эрмэлзэлтэй болох
Т1:Гамшгийн үе дэх хүүхэд хамгаалал	Хүүхдийн эрхүүдийг мэдэх Гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хүүхдээ хэрхэн хамгаалах тухай мэдэх	Хүүхдийн ямар ямар эрх байдгийг нэрлэх Гамшиг, онцгой байдлын үед үүсч болзошгүй хүүхдийн эрх зөрчигдөх нөхцлийг дурдах	Гамшгийн үед хүүхдийн эрх зөрчигдсөн үед эцэг эх, багш, холбогдох мэргэжлийн хүнд мэдээлэх
Т2:Гамшгийн эрсдэл	Гамшгийн эрсдэл, эмзэг байдлын ялгааг мэдэх Эрсдэлийг бууруулах арга хэмжээг мэдэх	Гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг тайлбарлах Орон нутаг болон сургуулийнхаа гамшгийн эрсдэлийг тодорхойлоход болон эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг хийх	Гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлийг бууруулах талаар оршин байгаа газрын олон нийтэд ухуулга хийх Болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, дэмжиж оролцох





<p>T1: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах</p>	<p>Орон нутагтаа амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээлэлтэй болох</p> <p>Эдгээр иргэдэд учирч болох эрсдэлийг тодорхойлох</p>	<p>Эрсдэлтэй нөхцөлд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн туслах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх, тэднийг гамшгийн үед хэрхэн аюулгүй байдлыг нь хангах дасгал сургуулилт хийх</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хандив, буяны ажил өрнүүлэх, эрсдэлийг бууруулах ажлыг санаачлан хийх, олон нийтийг уриалах</p>
<p>T2: Зудын эрсдэл, түүнийг бууруулах арга</p>	<p>Зудын тухай ойлголт, төрөл</p> <p>Зудын аюулаас учирч болох сөрөг нөлөөлөл</p>	<p>Зудын аюул үүсэх нөхцөл, тэдгээрийн төрөл хэлбэрийг тодорхойлох</p> <p>Зудын мал аж ахуйн салбарт үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар жишээ олж хэлэх</p> <p>зудын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд айл өрх ба хувь хүн юу анхаарах ёстойг талаар өөрийн бодлыг хэлэх</p>	<p>Зуд үүсэх байгалийн үзэгдлийг урьдчилан мэддэг уламжлалт арга ухаанаас мэддэг</p> <p>Зуд нь хүрээлэн буй орчны доройтлоос үүсдэгийг мэдэж байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах эрмэлзэлтэй болох</p>
<p>T1: Гал түймэр хэрхэн гардаг вэ?</p>	<p>Гал үүсэх нөхцөл, галын гурвалжинг мэдэх</p>	<p>Галын гурвалжин үүсэх нөхцлийг нэрлэх, энэ нөхцлийг үүсгэхгүй байх жишээг олж хэлэх</p>	<p>гал түймэр гарахад хүргэдэг хүчин зүйлүүдийг илрүүлж, өөрөө болон бусдад мэдэгдэх замаар гал гарахаас сэргийлэх арга хэмжээг авдаг</p>
<p>T1: Ой, хээрийн түймэр, түүнээс сэргийлэх арга</p>	<p>Хөдөө хээр хүний буруутай ямар үйл ажиллагаа (үнс, нурам, тамхи, чүдэнз, түүдэг гал, тээврийн хэрэгслийн оч баригч гэх мэт)-аас гал түймэр гарч болохыг мэдэх</p> <p>Гал түймэр гарахад нөлөөлдөг хүчин зүйлийг мэдэх</p>	<p>Хүний буруутай ямар үйлдлээс /бүрэн унтраагаагүй түүдэг гал, үнс нурам, тамхи, чүдэнз гэх мэт/ хөдөө хээр гал гарч болохыг тайлбарлах</p> <p>Гал түймэр гарахад нөлөөлдөг хүчин зүйл /цаг агаарын нөхцөл, салхи, агаарын чийгшил, хэм, улирлын байдал/ байдгийг мэдэж хэлэх</p>	<p>Хөдөө хээр явахдаа гал алдахаас сэргийлж анхаарал болгоомжтой байх талаар ухуулах, сурталчлах</p>

<p>T2: Ой хээрийн түймрийн үед авах арга хэмжээ, унтраах арга</p>	<p>Ой, хээрийн түймрийн ангилал, түймрийн шатлагын хоногийн давтамж ба түймрийг унтраахад нөлөөлдөг хүчин зүйлийн талаар ойлголттой болох</p> <p>Ой хээрийн түймрийг унтраах орчин үеийн болон уламжлалт аргыг мэдэх</p>	<p>Ой хээрийн түймрийг унтраахад ямар ямар хүчин зүйл нөлөөлдөг, яагаад гэдгийг бусдад тайлбарлах</p> <p>Ой хээрийн түймэр унтраах арга (цохих, шороогоор цацах, ус болон уусмалаар унтраах, шуудуу татах, цуравдах)-ыг хэрхэн хийх талаар хэлэх</p> <p>Ой хээрийн түймрээс амьд гарах, сэргийлэх уламжлалт аргыг эзэмшиж, бусдад хэлэх, таниулах</p>	<p>Гарын доорх материал ашиглан ой хээрийн түймрийг унтраахад шаардагдах ямар хэрэгсэл бэлтгэж үзүүлэх, түүнийгээ хэрхэн ашиглаж сурах талаар ярилцах</p> <p>Ой хээрийн түймрийг унтраах тохиромжтой цагийг хэлэх, яагаад гэдгийг тайлбарлах байдал</p>
<p>T1: Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга, тэмдэг тэмдэглэгээ,</p>	<p>Сургууль, гэртээ гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга замуудыг мэдэх</p> <p>Галын аюулгүйн тэмдэг тэмдэглэгээг мэдэх</p>	<p>Сургууль, гэртээ галын аюулгүй байдлыг хангах талаар юу хийж болохыг хэлэх</p> <p>Галын аюулгүйн тэмдэг тэмдэглэгээний хэлбэр, үүргийг хэлэх</p>	<p>Гал гарсан үед өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах</p> <p>Сургууль, гэрийнхээ бүдүүвчийг зурж, гал гарсан үед гарах замыг зурж тэмдэглэх, танилцуулах</p> <p>Галын аюулгүйн тэмдэг тэмдэглэгээний талаар найз нөхөддөө зааж сургах</p>
<p>T2: Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуурыг ашиглах арга</p>	<p>Гал унтраах анхан шатны багаж хэрэгслүүдийг мэдэх, тэдгээрийн үүргүүдтэй танилцах</p> <p>Зөөврийн гал унтраагуурыг ажиллуулах дараалал</p>	<p>Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл (хүрз, галын дэгээ, хөрөө, сүх, царил, хувин, жоотуу элстэй сав, устай сав, эсгий болон галд тэсвэртэй бүтээлэг, төрөл бүрийн гал унтраагуур)-ийг нэрлэж чадах</p> <p>Гал унтраагуурыг зөв ажиллуулах дарааллыг бүдүүвч зурган дээр тайлбарлах</p>	<p>Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд ашиглах, бусдад зааж сургах</p> <p>Гал унтраагуурыг хэрхэн ашиглах дарааллыг бүдүүвч зураг дээр тайлбарлах</p>





<p>T2: Гал түймрийн үед амь насаа хамгаалах арга, түлэгдэлтэнд үзүүлэх тусламж</p>	<p>Гал түймэр гарсан үед авах арга хэмжээг мэдэх Гал түймрээс өөрсдийгөө хамгаалах арга Түлэгдэлтийн зэргүүдэд үүсэх гэмтлийн шинж байдал, анхны тусламж үзүүлэх аргыг мэдэх</p>	<p>Гал гарсан үед ашиглах төлөвлөгөө гаргаж, түүнийг дагуу хэрхэн дадлага сургууль хийхээ танилцуулах Гал түймэр гарсан үед орон байрнаас хэрхэн аюулгүй гарах гарц болон гарах гарцгүй болон өөрт нь гал авалцсан үед ямар арга хэмжээ авахыг мэдэх Түлэгдэлтийн зэргүүдэд арьсанд илрэх гэмтлийн байдлыг нэрлэх Халууны түлэгдэлтийн анхны тусламж үзүүлэх аргыг хийж үзүүлэх</p>	<p>Гал түймрийн үед орон байрнаас хэрхэн аюулгүй гарах болон гарах гарцгүй тохиолдолд хэрхэн аюулгүй байдлаа хангах дадлага сургуулилт хийх, бусдадаа зааж сургах Түлэгдэх аюулын талаар бусдад сэрэмжлүүлдэг, өөрөө өртөхөөс сэргийлдэг байх, шаардлагатай тохиолдолд тусламж үзүүлэх чадвартай</p>
<p>T1: Хүчтэй салхи шурганаас хамгаалах арга</p>	<p>Хүчтэй цасан шуурга, хүчтэй шороон шуургыг үүсэх нөхцөл, учруулах хор уршгийг мэдэх Хүчтэй салхи, шуурганаас өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах аргыг эзэмших</p>	<p>Цаг агаарын мэдээнээс хүчтэй салхи, цасан болон шороон шуурга болох нөхцлийг мэдэж чаддаг байх Цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээг хүлээн авсан тохиолдолд амь нас, эд хөрөнгөө хэрхэн хамгаалах аргыг хэлэх, тайлбарлах</p>	<p>Цаг агаарын мэдээг өдөр тутмын амьдралдаа ашиглах, Найз нөхөд, дүү нартаа хүчтэй салхи, шуурганы учруулах хор уршгийн талаар болон түүний учруулах аюулаас хэрхэн хамгаалах талаар хэлэх, сэрэмжлүүлэг өгөх</p>
<p>T2: Үерийн аюулаас хэрхэн хамгаалах вэ?</p>	<p>Үерийн аюул үүсэх шалтгаан, үерийн төрлүүдийг мэдэх Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх аргуудыг мэдэх Үер тохиолдсон үед авах арга хэмжээ</p>	<p>Үер үүсэх цаг агаарын болон газарзүйн нөхцлийг тайлбарлах Үерт өртөхөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах уламжлалт болон ердийн аргыг ашиглаж чадах</p>	<p>Цаг агаарын мэдээг тогтмол үзэх, хэрэглэх Үерийн үед өндөрлөг газарт гарахыг санах</p>
<p>T2: Гол, мөрний усны осол, тусламж үзүүлэх арга</p>	<p>Жилийн аль ч улиралд гол, мөрний усны осол тохиолдож болохыг мэдэх Живсэн хүнд үзүүлэх анхан шатны тусламжийг мэдэх</p>	<p>Гол, усыг гатлах, түүний ойр орчимд тоглохдоо усанд живэх, эрэг нурах, голын мөс цөмрөх зэрэг аюул байдлыг хэлэх Живсэн хүнд анхан шатны тусламжийг зөв үзүүлж сурах</p>	<p>Гол мөрний усыг насанд хүрсэн хүний хяналтгүйгээр гатлахгүй, ойр орчимд нь тоглохгүй байх, энэ талаар бусдад санаа тавих Живсэн хүнд тусламжийг зөв үзүүлэхийг хийж сурах, бусдад заах</p>

<p>T1: Газар хөдлөлт, газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах арга</p>	<p>Монгол орон газар хөдлөлтийн ямар бүсэд оршдогийг мэдэх</p> <p>Газар хөдлөлтийн аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх аргыг мэдэх</p> <p>Газар хөдлөлтийн үед хэрхэн ажиллах, амь насаа аврахыг мэдэх</p>	<p>Газар хөдлөлтийг хэмжих балл, магнитудын ялгааг хэлэх, мэдэх</p> <p>Газар хөдлөлт болоход өөрт нь аюул учруулж болох нөхцлийг / хананд өлгөсөн эд зүйл унах, цонх хагарах/ нэрлэж, хэрхэн аюулгүй болгохыг / эд зүйлийг хананд нь бэхлэх, цонхны ойрхон унгахгүй байх, цугларах цэг, газар/хэлэх</p> <p>Газар хөдлөлтийн үед "хэвт, нуугд, хүлээ" гэсэн дарааллыг сахих болон дараа аюулгүй байдлаа хэрхэн хангахыг хэлэх, зөв үйлдэх</p>	<p>Гадаадад болон монгол оронд тохиолдож байсан газар хөдлөлтийг нэрлэх</p> <p>Газар хөдлөлтийн үед өөрт болон бусдад аюул учруулж болох нөхцлийг хэрхэн арилгах арга замыг бусдад зааж сургах</p> <p>Газар хөдлөлтийн үед болон дараа юу хийж болохгүйг зөв нэрлэх</p>
<p>T1: Аянга, цахилгаанаас хамгаалах арга</p>	<p>Аянга буух, нэрвэгдэх боломжийг таньж мэдэх, өөрийгөө хамгаалах аргуудыг мэдэх</p>	<p>Аянганд нэрвэгдэхээс урьдчилан сэргийлэх аргыг хэлэх</p> <p>Аянга цахилгаантай борооны үүл, тэнгэрийн байдлыг уламжлалт болон орчин үеийн аргаар ялган таних</p>	<p>Аянга, цахилгаантай бороотой үед хэрхэн өөрийгөө хамгаалах ёстой мэдэх, бусдад ойлгуулах</p>
<p>T2: Төөрсөн үед өөрийгөө аврах арга</p>	<p>Төөрсөн үед /хөдөө, хээр, ой мод/ зүг чиг тодорхойлох аргуудыг мэдэх</p> <p>Ой мод, хээр хөдөө төөрсөн үед аюул, ослын дохио өгөх арга</p>	<p>Зүг, чигийг соронзон орон ба одон орон, газар орны шинж тэмдгээр хэрхэн тодорхойлохыг тайлбарлаж чаддаг байх</p> <p>Төөрсөн үед ямар дохионууд өгч болохыг хэлэх, яаж дохио өгөхийг хийж үзүүлэх</p>	<p>Зүг, чигийг соронзон орон ба одон орон, газар орны шинж тэмдгээр хэрхэн тодорхойлохыг мэдсэнээр амьдралдаа хэрэглэх</p> <p>Найз нөхөд, гэр бүлийнхэндээ өөрийн олж авсан мэдлэгээ хуваалцах, зааж сургах</p>





<p>T2:Тэсэж амьд үлдэх арга</p>	<p>Хээр хөдөө отоглох, түүдэг гал түлэх, гарын доорх материал ашиглан оромж, хоол хүнс бэлтгэх аргыг мэдэх</p>	<p>Хээр хөдөө отоглох, түүдэг гал түлэх, гарын доорх материал ашиглан оромж, хоол хүнс бэлтгэх аргыг хэрхэн хэрэглэхийг бусдадаа зааж сургах</p>	<p>Шаардлагатай хээр хөдөө отоглох, түүдэг гал түлэх, гарын доорх материал ашиглан оромж, хоол хүнс бэлтгэж сурах</p>
<p>T2:Химийн хортой, аюултай бодисын аюулаас хамгаалах арга</p>	<p>Химийн хортой, аюултай бодис / мөнгөн ус, хоолны цууны хүчил, алимны хүчил, лимоны хүчил, цианит натри/-ын аюулаас хамгаалах арга хэмжээ</p> <p>Ахуйн шатамхай, тэсрэмтгий бодис (үнэртэй ус, агааржуулагч, цэвэрлэгээний шингэн, будаг, будаг шингэлэгч, савласан хий гэх мэт) бүхий эд зүйл гэж юу болохыг мэдэх</p> <p>Шатамхай, тэсрэмтгий эд зүйл гэдгийг сав баглаа, боодолд хэрхэн тэмдэглэдгийг мэдэх</p> <p>Хялбархан шатдаг, тэсэрдэг эд зүйлийг аюулгүй ашиглах аргыг мэдэх</p>	<p>Химийн бодисын осол үсэх шалтгаан, хамгаалах арга хэмжээг тайлбарлах</p> <p>Хялбархан шатдаг, тэсэрдэг шинжийг ямар тэмдэглэгээгээр илэрхийлдгийг тэмдэг, тэмдэглэгээг харуулсан зурагт дүрслэл дээр ялгаж тайлбарладаг байх мэддэг байх</p> <p>Эдгээр эд зүйл /ахуйн хэрэглээний хий, үнэртэн, цэвэрлэх, ариутгах шингэн/-ыг аюулгүй хэрэглэж чаддаг байх</p>	<p>Химийн хортой, аюултай бодисын аюул, ослоос урьдчилан сэргийлэхэд хувь хүн чухал үүрэгтэйг бодит жишээн дээр тайлбарлах, энэ талаар хүмүүст мэдээлэл хүргэх, санал бодлоо хуваалцах</p> <p>Эд зүйлийн сав баглаа, боодлын тэмдэг тэмдэглэгээ, зориулалтыг харж хэвших</p> <p>Хялбархан шатдаг, тэсэрдэг эд зүйлийг аюулгүй ашиглах аргуудыг тайлбарладаг байх</p>



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ӨСВӨРИЙН АВРАГЧ БҮЛЭГТ ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: АНХАН ТҮВШИН







СЭДЭВ 1: ГАМШГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Тулгуур ойлголт: гамшгийн тухай ойлголт, аюул, осол, аюулт үзэгдлийн тухай ойлголтыг өгнө. Монгол оронд тохиолдож болзошгүй гамшгийн аюулыг гарал үүслээр нь 2 ангилдаг болохыг ойлгуулах.

Аюул, осол гэж юу вэ?

Байгаль орчин, нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлөх, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгөнд хохирол учруулж болзошгүй аливаа үзэгдэл, үйл явдлыг АЮУЛ гэнэ.

Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулж, нийгэм, эдийн засгийн үйл явцыг тасалдуулж, хүрээлэн буй орчныг доройтуулж болох байгалийн үзэгдлийг АЮУЛТ ҮЗЭГДЭЛ гэнэ

Үйлдвэрлэл, техник, технологийн горим зөрчигдсөний улмаас хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учруулах үйл явдлыг ОСОЛ гэнэ.



Гамшиг гэж юу вэ?

Байгалийн аюулт үзэгдэл, осол тохиолдсоны улмаас хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд нэрвэгдсэн орон нутаг өөрсдийн хүч нөөцийг ашиглан тэмцэх боломжоос давсан их хэмжээний хохирол учрах, нийгмийн үйл ажиллагаа ноцтой алдагдах нөхцлийг Гамшиг гэнэ.

Гамшгийг хэрхэн ангилах вэ?

Манай оронд тохиолдож болзошгүй гамшгийн аюулыг гарал үүслээр нь дараах бүүдүүвчид заасан байдлаар ангилж болно.



Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: гамгийн тухай ерөнхий ойлголт өгөхийн тулд хичээлийн эхэнд урьдчилан бэлтгэсэн гамшгийг харуулсан гэрэл зураг, зурсан зураг зэргийг харуулна. Энэ нь харааны танин мэдэхүйг ашиглан дүгнэлт хийлгэх зорилготой. Зургаас их хэмжээний хохирол учрах, хүмүүсийн хэвийн амьдралын нөхцөл алдагдсан нөхцлийг гамшиг гэж нэрлэдэг болохыг дүгнүүлнэ.

Үйл ажиллагаа 2: Багаар ажилуулахдаа бүлгийн сурагчдын тооноос хамааруулж багт хуваагаарай. Нэг багт ойролцоогоор 3-4 сурагч байх нь тохиромжтой байдаг. Багуудыг гамшигтай холбоотой нэртэй болохыг сануулна. Дараа нь баг тус бүрт үзүүлдэнд өгсөн гамшгийн ангиллыг тус бүрд нь хайчлаад тарааж өгнө. Баг бүр өгсөн материалыг ашиглан зөв ангилах даалгаврыг өгнө. Хамгийн түрүүлж зөв ангилсан багийг шалгаруулна. Төгсгөлд нь Монгол оронд ихэвчлэн тохиолддог гамшгийг нэрлүүлнэ.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: гамшийг тодорхой ойлгомжтой харуулсан зурагт үзүүлэн аль болох олон төрлөөр бэлтгэнэ. Гамшгийн ангиллыг урьдчилан хэвлэж хайчилж бэлдсэн байна.

СЭДЭВ 2. ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР АЖИЛЛАХ

Тулгуур ойлголт: Хүн амд учирч болзошгүй гамшгийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг төвлөрсөн мэдээллийн хэрэгсэл, тусгай хэрэглээний холбоо, орон нутгийн болон олон нийтийн радио, телевиз, мэдээлэл, харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл”-ийг нэн даруй хүргэх хэрэгтэйг ойлгуулна.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:






Үйл ажиллагаа 1: багш урьдчилан дуу хураагуурт гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн олон хэлбэрүүдийг бичиж бэлтгэсэн байна. Ингээд дэс дараалуулан сонгоод хэзээ, хаана энэ дохиог сонсож байсан талаар харилцан ярилцана.

Үйл ажиллагаа 2: харилцан ярилцсаны дараа сурагчийн номны дараах хүснэгтийг унших даалгвар өгнө.

Сонссон дохиог аль ангилалд оруулж болохыг дэвтэртээ тэмдэглэх даалгавар өгнө. Дараа нь багш сурагчийн номны дараах хүснэгтийг ашиглан зөв ангилсан



эсэхээ дүгнэхийг сануулна. Энэ үйл ажиллагаагаар ангилах, дүгнэх чадварыг хөгжүүлнэ.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: дуу хураагуур, чанга яригч, гар утсанд ирдэг мессеж, тээврийн хэрэгслийн төрөл бүрийн дохионууд, радио, телевизээр

	Сэрэмжлүүлэх мэдээ	Гамшгийн аюулын дохио
Хүргэх хэлбэр, утга	“Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гэсэн толгойтой “ХАРАНГА” дохиотойгоор мэдээллийн хэрэгслээр дамжуулна.	“Анхаараарай, анхаараарай! Онцгой байдлын албанаас (Засаг даргын тамгын газраас) ярьж байна.”/Гамшгийн аюулын нэр/ аюулын түгшүүр” гэж зарлана. Жнь: түймрийн аюулын түгшүүр гэх мэт
Ашиглах техник хэрэгсэл, сүлжээ	Төвлөрсөн зарлан мэдээллийн хэрэгсэл Радио, телевиз Телефон утас Гар утас Мэдээллийн сайт	Төвлөрсөн зарлан мэдээллийн хэрэгсэл Байгууллагын дотоод холбооны төхөөрөмж, Мэдээллийн дэлгэц, Төрөл бүрийн дохиоллын хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, Чанга яригч; Бие холбоочин



ихэвчлэн дуугардаг дохио, шторкууд, галын машины дуут дохио, яаралтай түргэн тусламж, цагдаагийн машины маякийн дуу, гэрэл чийдэн



СЭДЭВ 3. ГАЛ ТҮЙМЭР ХЭРХЭН ГАРДАГ ВЭ?



Тулгуур ойлголт: Гал бол түлш, хүчилтөрөгчийн харилцан үйлчлэлээр бий болон гэрэл гаргаж, дулаан ялгаруулдаг химийн үзэгдэл юм. Гадаад хүчин зүйл болох дулаан нь харилцан үйлчлэл эхлэхэд нөлөөлдөг. Галыг ихэвчлэн түлш, хүчилтөрөгч, дулаанаас бүтсэн гурвалжингаар илэрхийлдэг. Уг гурвалжин дотор түлш, хүчилтөрөгч, дулаан 3 нь гурван тал болж байдаг учир галыг унтраахын тулд энэ гурвалжинг эвдэх хэрэгтэй. Хэрвээ гурвалжинг бүрдүүлж байгаа зүйлсийн аль нэг нь л байхгүй бол гал асч чадахгүй.

Галын сайн ба муу тал

Галын сайн тал	Галын муу тал
Гэрийн зуух, түүдэг гал, лаа,	Гэр оронд түймэр гарах, хувцас шатах, ой шатах

Муу гал нь хүний амьдрах орчин, эрүүл мэндэд нэн аюултай, хянах бололцоогүй, эд материалын асар их хохирол учруулдаг үйл явц юм.

Галын хүний амь насанд учруулах аюул нь юу вэ?

ХОРТОЙ ХИЙНД УГААРТАХ

гал гарч байх үед агаар дахь хүчилтөрөгч багасан амь насанд аюултай хортой хий ялгардаг. Гал түймрийн улмаас угаартсан хүмүүсийн тоо түлэгдсэн хүмүүсийнхээс 2-3 дахин их байдаг байна.

ГАЛЫН ДӨЛӨНД ТҮЛЭГДЭХ

гал гарч байх үед их хэмжээний халалт үүсэх нь хүний бие махбодод онц аюултай. Өрөөг бүхэлд нь хамарсан гал түймрийн үед температур нь 593°C хүрдэг байна.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Хичээлийн эхэнд галын зураг харуулна. Ингээд гал ямар ач холбогдолтой вэ? Ямар хор хөнөөлтэй болохыг асууж доорх хүснэгтийг бөглүүлнэ.

Галын ач холбогдол	Галын хор холбогдол
-	-
-	-
-	-

Үйл ажиллагаа 2: Хүснэгтийг бөглөж дууссаны дараа гал гарахад нөлөөлөх хүчин зүйлсийн тухай ярилцана. Хамгийн чухал нь гал гарахад түлш хэрэгтэй гэдэг санааг гаргуулах нь чухал. Ингэхийн тулд шатдаг болон шатдаггүй эд зүйлсийн зургийг харуулаад ангилуулаарай. Самбарыг хоёр хэсэгт хуваагаад шатдаг ба шатдаггүй гэж ангилуулна. Сурагчид зургуудыг зөв байрлуулна.

Шатамхай	Шатдаггүй
Зураг наана	Зураг наана






Үйл ажиллагаа 3: Шатаж буй галыг эрчимжүүлэх, галыг унтраах хүчин зүйлсийн нэрийг бичсэн хуудас харуулж ангилуулаарай.

Галыг дэмжих хүчин зүйлс	Галыг унтраах хүчин зүйлс
-	-
-	-
-	-

Эдгээр үйл ажиллагааны дараа галын гурвалжин харуулж бөглүүлээд дүгнэлт гаргуулаарай.



Үйл ажиллагаа 4: Гал хөгжөөнт тоглоомыг тоглуулж хичээлийг дуусгана.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: мод, түлээ, хуванцар, хоол хүнс зэрэг шатдаг зүйлсийн зураг. Төмөр, чулуу зэрэг шатдаггүй эд зүйлсийн зураг. Агаар, нүүрсхүчлийн хий зэрэг үгсийг бичсэн хуудаснууд бэлтгэнэ.

СЭДЭВ 4. АХУЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА, ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ



Тулгуур ойлголт: Гал түймэр нь бусад гамшгуудтай харьцуулахад урьдчилан сэргийлэх боломжтой юм. Гал түймрээс урдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга зам бол гал гаргахгүй байх явдал юм.

Гэр, сургуулийнхаа ойр орчимд байгаа гал алдах аюултай бүх зүйлсийг олж илрүүлэн, аюулгүй болгох нь гал түймрээс урьдчилан сэргийлэх үндсэн арга юм.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Гал түймрээс урдчилан сэргийлэх боломжтой юу? гэсэн асуулт тавина. Хүүхдүүдийг 3 багт хуваагаад баг бүр галаас урьдчилан сэргийлэх байж болох аргуудыг дэвтэртээ бичих даалгавар өгнө. Бичиж дууссан дараа багууд танилцуулга хийнэ.

Үйл ажиллагаа 2: Танилцуулсны дараа сурагчийн номны зургийг харуулж та нарынхтай хэр таарч байгааг дүгнүүлнэ.

Үйл ажиллагаа 3: Эдгээр аргуудаас та нарын хэрэгжүүлж чадах болон



чадахгүй арга байна уу? гэж асуугаад доорх хүснэгтийг бөглүүлээрэй.

Би хэрэгжүүлж чадна	Би хэрэгжүүлж чадахгүй

Хүснэгт бөглөж дууссаны дараа бид галаас урьдчилан сэргийлж чадна гэж өөртөө болон бусдад итгэл дүүрэн хэлүүлээрэй.

Үйл ажиллагаа 4: Гал түймрийн аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээг 3 багт тэнцүү хуваан өгч ямар утга санаа агуулсныг тайлбарлах даалгавар өгнө.

Багууд өөрсдийн бодол санааг тайлбарлаж дууссаны дараа сурагчийн

		Нүүлгэн шилжүүлэлтийн гарцын чиглэл
		Шатаар доош буух нүүлгэн шилжүүлэлтийн гарц
		Шатаар дээш гарах нүүлгэн шилжүүлэлтийн гарц
	Нүүлгэн шилжүүлэлтийн чиглэл Нүүлгэн шилжүүлэлтийн үндсэн гарц руу гарах хөдөлгөөний чиглэлийг заана Нүүлгэн шилжүүлэлтийн нөөц гарц руу гарах хөдөлгөөний чиглэлийг заана	

номноос хэр зэрэг зөв тайлбарласан болохыг дүгнэх даалгавар өгнө. Ингэхдээ баг бүр бусад багийнхандаа өөрсдийн гаргасан алдаатай болон зөв хариулсан эсэхийг дүгнэж хичээлийг дуусгаарай.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: Галаас урьдчилан сэргийлэх аргуудыг харуулсан зураг. Гал түймрийн аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээг харуулсан зураг бэлтгэнэ.

СЭДЭВ 5. ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭР, ТҮҮНЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА

Тулгуур ойлголт: Ой хөвчид мод, ургамал хяналтгүйгээр үргэлжлэн шатахыг **ойн түймэр** гэнэ. Тал хээрт хүний хяналтаас гадуур тархан шатаж байгаа галыг **хээрийн түймэр** гэнэ.

Ой хээрийн түймрийг тархалтыг дэмждэг 3 зүйл байдаг.

- цаг агаарын байдал,
- улирлын байдал буюу түлшний хэмжээ
- газарзүйн байрлал буюу газар нутгийн хотгор, гүдгэрийн байдал

Цаг агаарын байдал түймэрт дараах байдлаар нөлөөлнө:





Салхи Их салхи түймрийн тархалтыг нэмэгдүүлнэ.	Агаарын чийгшил Хур тунадас орох үед агаарын чийгшил нэмэгдсэнээр түймрийн тархалт багасаж, зарим тохиолдолд унтардаг.	Агаарын температур Их халуун байхад шатах эд зүйл чийгээ хурдан алдсанаар түймрийн тархалтыг нэмэгдүүлнэ.
---	---	--

Улирлын байдал түймэрт дараах байдлаар нөлөөлнө:

Хавар Хаврын эхэн үед ихэнхдээ хуурай өвстэй газраар түймэр гардаг ба түймрийн тархалтын хурд нь салхины хурдаас хамаардаг Хаврын сүүл үед тогтонги хэлбэрийн гадаргуугийн түймэр гарах ба хөрсөн дээрх зүйл шатдаг. Энэ үед мод шатаж ахиж ургахгүй болдог.	Зун Түймэрт газрын дээрх ойн унаш, хөвд бүрэн шатна. Гүн шатсан үедээ түймэр хөрсний гүний түймэр болдог	Намар Түймэр газрын гадаргууд гарч зөвхөн өдрийн цагаар тархаж, шөнийн цагаар шатлага нь удааширна.
--	---	--

Газарзүйн байрлал нь түймэрт дараах байдлаар нөлөөлнө. Нар их хэмжээгээр тусдаг уулын энгэр газар, баруун өмнөд, баруун хэсгээрээ дулаан, бас хуурай байдаг. Уулын хойд хэсэгтэй харьцуулахад энд түймэр гарахад бэлэн байдаг. Тал газартай харьцуулахад эгц босоо газарт түймэр хурдан тархдаг. Яагаад гэвэл галын дөл дээшээ өгсөн шинээр түлшийг хатаан, шатахад бэлэн болгодог.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Хичээлийн эхэнд ой шатаж байгаа болон тал хээрт гарч буй галын зураг үзүүлнэ. Эндээс ойн болон хээрийн түймэр гэж ангилдаг болохыг ойлгуулна.

Үйл ажиллагаа 2: Дараа нь сурагчдыг 2 багт хуваагаад ой хээрийн түймэр гарах шалтгаануудыг багаараа ярилцаад, бичих даалгавар өгнө. Багууд мэдээллээ танилцуулсаны дараа сурах бичгийн доорх хүснэгтийг харуулж зөв дүгнэсэн эсэхээ шалгаж дүгнэх даалгавар өгнө.

Байгалийн гэнэтийн үзэгдэл /Түймэр гарах шалтгааны 10%-ийг эзэлнэ/	Хүний үйл ажиллагаа /Түймэр гарах шалтгааны 90%-ийг эзэлдэг/
Аянга, цахилгаан Хөрсөн доорх хүлэр өөрөө авалцах	Ил задгай асгасан цогтой үнс нурам Унтраалгүй хаясан тамхи, чүдэнз Зуухны яндангаас хаясан очтой хөө Оч баригчгүй яндантай трактор, машин, мотоцикль Хүүхэд галын аюултай зүйлээр тоглох Бүрэн унтраагүй болон ил задгай түлсэн гал Дохионы пуужин харвах Галт сумаар буудах

Үйл ажиллагаа 3: Ой хээрийн түймрээс учирч болох хор хохирлын талаар асууж ярилцсанаар түүнээс яаж урьдчилан сэргийлж болох вэ? гэсэн асуулт тавьж баг тус бүр ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах



даалгавар өгнө. Зөвлөмжийг баг тус бүр танилцуулсны дараа хамгийн оновчтой боловсруулсан зөвлөмжийг зураг, анхааруулах тэмдэг, дохиог ашиглан том цаасан дээр дахин ханын сонин хэлбэрээр бичиж сургуулийн зааланд байрлуулж бусдадаа мэдээллээ дамжуулаарай.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: том цаас, маркер, ой, хээрийн түймрийг харуулсан зураг.

СЭДЭВ 6. ХҮЧТЭЙ САЛХИ, ШУУРГАНААС ХАМГААЛАХ АРГА

Тулгуур ойлголт: Дэлхий олон километр зузаан агаар мандлын давхаргаар хучигдсан байдаг. Агаар нь байнгын хөдөлгөөнд оршдог. Энэхүү хөдөлгөөн нь нэгдүгээрт, нар усан ба хуурай гадаргууг жигд бус халааснаас тэдгээрийн дээрх агаарын массын температур ялгавартай болсноор, хоёрдугаарт агаар мандлын даралтын ялгавраар нөхцөлдөн үүсдэг.

Агаарын массын усан ба хуурай газарт харьцангуйгаар шилжих хөдөлгөөнийг салхи гэж нэрлэдэг. Салхийг тодорхойлох үндсэн хэмжигдэхүүнд түүний хурд, зүг /хөдөлгөөний чиглэл/, хүч ордог. Энэхүү хэмжигдэхүүнээсээ хамаараад салхи нь хүчтэй, сул гээд олон хэлбэртэй болдог.

- Хүчтэй салхи: салхины хурд 16 м/с түүнээс их, 3 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх агаарын урсгал

Манай орны салхи, шуурга барилга байгууламжийг эвдэх, ой модыг булгалах, тээврийн хэрэгслийг эвдэж гэмтээх бусад зүйлийг хийсгэх, хүн, мал амьтан туугдах, төөрөх зэрэг аюул учруулдаг. Хүйтэн сэрүүний улиралд хамгийн түгээмэл тохиолдох аюул нь хүмүүс төөрч, улмаар осгох явдал байдаг.

Хүүхдүүд хүчтэй салхи, шуурганы үед төөрөх улмаар хөлдөх, осгох зэргээр амь насаа алдах аюул түгээмэл гардаг. Хүйтний нөлөөгөөр цусны судсууд агшсанаас эд эсийн бодисын солилцооны хэвийн үйл ажиллагаа алдагдаж гэмтэхийг **хөлдөлт** гэнэ.

Хүний бие махбодь бүхэлдээ даарч хөрснөөс хөдөлж чадахгүй болж хөшиж үхлүүт байдалд орохыг **осголт** гэнэ.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Өмнөх хичээлийн дараа багш дараагийн цугларалтанд ирэхдээ өдөр бүрийн цаг агаарын мэдээг бичиж тэмдэглэж ирэх даалгавар өгөөрэй. Хичээлийн эхэнд хүчтэй шуурга, хүчтэй цасан шуурга, хүчтэй шороон шуурганы зураг харуулна. Эндээс шуургыг ийм 3 хэлбэрт хувааж үздэг тухай ойлголт авна. Ингээд сурагчийн номны доорх хүснэгтийг үзүүлнэ.

Хүснэгтийг ажиглуулж ямар шинж чанарыг ашиглан дээрх 3 хэлбэр ангилсан болохыг дүгнүүлээрэй.

Үйл ажиллагаа 2: Өмнөх хичээлд өгсөн гэрийн даалгавраа бүлгийн гишүүдээс 2-оос доошгүй сурагчаар уншуулна. Үүний дараа доорх хүснэгтийг харуулж ойрын өдрүүдэд салхины хурд ямар байсан аль ангилалд орж болох талаар ярилцаарай.

Салхины
хурд
м/с

Нэршил

Салхины илрэх шинж
ба учруулах аюул

Цаг агаарын мэдээгээр
хүргэх хэлбэр





14 хүртэл	Зөөлөн	Навчис сэргижнэж, нарийхан мөчир туялзана. Өвсний толгой найгалзана. Туг, дарцаг дэвэлзэнэ. Цаас хийснэ. Шороо босно. Дээлийн хормой дэrvэнэ.	“Цэнхэр залаа” аятайгаар салхины хурдыг зааж зарлана.
15-29	Хүчтэй	Барилгын муудсан болон хөнгөн материалаар хийсэн дэvvэр, тоосгон яндан нурна. Мод тахийж мөчир нь хугарна.	“Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гэсэн тайлбартайгаар салхины хурдыг зааж зарлана.
30-аас дээш	Аюултай	Мод, байшин, гэр, хашаа нурна. Хүн, жижиг мал ойчно. Гэр нурна. Тэнгэр харанхуйлна.	“Харанга” дохиотойгоор “Цаг агаарын нэн аюултай буюу гамшигт үзэгдлээс сэpэмжлүүлэх мэдээ” гэсэн тайлбартайгаар салхины хурдыг зааж зарлана.

Үйл ажиллагаа 3: Бүлгийн гишүүдийг 3 баг болгон хувааж салхины хурдын илрэх шинжийг харуулсан зургуудыг зуруулна. Уг зураг юуг илэрхийлсэн утгатай болохыг багаараа ярилцаад бусад багийнхандаа танилцуулна. Дараа нь тэмдэг тэмдэглэгээний тайлбарыг багш үзүүлээд зөв таамагласан багийг шалгаруулаарай.

Салхины хурдын тэмдэг тэмдэглэгээ

1	2
Зөөлөн салхи	
3	4
Хүчтэй салхи	
5	6
Аюултай салхи	

Үйл ажиллагаа 4: Баг тус бүрт хүчтэй салхи шуургаанаас гарч болох хор хохирлын талаар жагсаан бичээд бусдадаа танилцуулах даалгавар өгнө.

Хүчтэй салхи шуургаанаас гарч болох хор хохирлууд



-
-
-

Багууд танилцуулсаны дараа ижил төстэй хохирлуудыг багш самбарт ялган бичих эсвэл улаан маркераар зөвлөж тодруулна. Эндээс хөлдөх, осгох гэсэн үгэнд тулгуурлан дараагийн үйл ажиллагаанд шилжээрэй.

Үйл ажиллагаа 5: Ямар нэг эрхтэн нь хөлдсөн эсэхийг ямар шинж тэмдгээр мэдэж болохыг асууна. Сурагчдын хариулсан хариултыг самбарт бичиж зөв хариултуудын өмнө зөвлөнө.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: том цаас, үзүүлэн

СЭДЭВ 7.АЯНГА, ЦАХИЛГААНААС ХАМГААЛАХ АРГА

Тулгуур ойлголт: Аянга гэдэг нь цэнэгжсэн үүлнүүдийн хооронд эсвэл үүл, газар хоёрын хооронд явагдах цахилгааны ниргэлт юм. Ниргэлтийн үеийн дуут ниргэлгээ явагдаж буй замыг цахилгаан гэх ба энэ галт замын дагуу агаар агшин зуур асар хүчтэй халж, гэнэт тэлэлтэд орсноос хүчтэй дуу гарна. Энэ үед гэрлийн хурд дуунаас хурдан тул эхлээд гэрэл цахилгаан нь харагдаж, дараа нь дуу нь сонсогддог.

Аянга цахилгаантай бороо орох гэж буй шинж байдал:

- Гол төлөв үдээс хойш хар бараан өнгийн борооны үүл маш хурдан хөгжин томорч, дээд хэсэг нь уулын огцом шовх орой шиг янз бүрийн хэлбэр дүрстэй болох
- Амьсгалахад бэрхшээлтэй бүгчим, салхигүй болох
- Байгаль орчин нам, гүм болох, тэнгэр харанхуй манантай юм шиг болох
- Холын дуу чимээ тод сайн сонсогддог болох
- Тэнгэрийн дуу ойртох

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Бүлгийн гишүүдийг 2 багт хуваана. Эхний багт газарзүй, физикийн хичээлүүдэд үзсэн мэдлэгээ ашиглан аянга цахилгаан яагаад буудаг тухай мэдээлэл бэлтгэхийг хүснэ. Дараагийн багт аянга цахилгаанаас хэрхэн хамгаалах талаар мэдээлэл боловсруулахыг хүснэ. Багууд бэлтгэсэн мэдээллээ танилцуулсны дараа сурагчийн номыг уншихыг сануулна.





Аянганаас хамгаалах арга

- Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг цаг тухайд нь хүлээн авах
- Аянга зайлуулагчтай эсэхийг мэдэх
- Урьдчилан сэргийлэх мэдээ хүлээж аваад эсвэл дээр өгүүлснээр үүлний шинж байдлаар тэнгэр муудах хандлагатайг ажигламагцаа аадар борооноос урьтаж нөмөр газарт нуугдах
- Аянга цахилгаантай аадар орж байгаа тохиолдолд хоргодох газар олж орох
- Мал, амьтадаа хашаа, хороонд нь оруулах
- Аянга татах шинж чанар бүхий автомашин, мотоцикль, унадаг дугуй гэх мэт техник хэрэгсэл болон бусад метал зүйлсээс хол байх
- Өндөр модноос хол байх
- Аянга нижигнэх дуу гармагц морь болон унаанаас бууж, доош суух
- Гэрийн дотор яндан зуух болон гэрийн ханатай ойр байх аюултай

Үйл ажиллагаа 2: Дараа нь эхний багт **Аянга, цахилгааны үед юу хийх вэ?** 2-р багт **Аянга, цахилгааны дараа юу хийх вэ?** гэсэн нэр өгч сурагчийн номноос холбогдох мэдээллүүдийг уншаад бусад багийнхандаа тайлбарлаж өгөх даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 3: Бүлгийн гишүүд хамтдаа аянга цахилгаанаас урьдчилан сэргийлэх аргууд нэртэй ханын сонин бэлтгэж сургуулийнхаа хананд байрлуулж бусдадаа энэхүү мэдээллийг өгөх даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 4: Хичээлийн төгсгөлд **“Цахилгаан дамжуулах”** тоглоом тоглуулж хичээлийг төгсгөөрэй.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: том цаас маркер,



СЭДЭВ 8. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА

Тулгуур ойлголт: Газар хөдлөлт нь учруулах хөнөөл ихтэй, урьдчилан таамаглах боломжгүй, гэнэт асар богино хугацаанд тохиолддог хамгийн аюултай үзэгдэл тул газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдлаа хангаж, гамшгийн үед юу хийхээ мэддэг байх нь амь нас, эд хөрөнгө хохирохоос сэргийлж чадна.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Багш ойрын жилүүдэд гадаад орнуудад тохиолдсон газар хөдлөлтийн жишээ баримтыг сурагчдаас асууж ярилцана. Энэ ярилцлагаас газар хөдлөлтийн үед асар их хэмжээний хохирол учирдаг учраас урьдчилан сэргийлэх, газар хөдлөлтийн аюулаас хамгаалах боломжтой гэсэн дүгнэлтэнд хүргэнэ.

Үйл ажиллагаа 2: Газар хөдлөлтөөс гэр бүл, найз нөхдөө хамгаалах 7 алхмыг ойлгуулахын тулд бүлгийн гишүүдийг 7 багт хуваана. Баг бүрт алхмуудыг агуулсан зураг мэдээллийг тараан өгч бусад багийнхандаа тайлбарлаж өгөх даалгавар өгнө.

1-р алхам: Гэр орон, сургууль дотор газар хөдлөлтийн үед





аюул учруулж болзошгүй зүйлийг илрүүлж, засаж янзлах

Гэр орон, анги танхимаа аюулгүй болгохын тулд газар хөдлөлтийн чичирхийллийн үед унаад гэмтэл учруулж болох бүх зүйлийг шалгаж, бөхөлж аюулгүй болгоно.

2-р алхам: Газар хөдлөлтийн үед хэрхэн ажиллах төлөвлөгөөг хамтдаа хийх

3-р алхам: Төлөвлөгөөний дагуу дадлага хийх

Гэр бүл, анги хамт олноороо хэлэлцэж боловсруулсан төлөвлөгөөгөө жилд нэг удаа дасгал сургуулилт хийж шалгаж байх хэрэгтэй.

4-р алхам: Гамшгийн үед шаардлагатай эд зүйлсийг бэлтгэх

5-р алхам: Газар хөдлөлтийн чичирхийллийн үед өөрийгөө хамгаалах /чичирхийлэл ихдээ л 1 минут үргэлжилдэг/ “ХЭВТ, НУУГД, ХҮЛЭЭ”

6-р алхам: Газар хөдлөлтийн дараа өөрийгөө болон орчин тойрноо шалгах

Үйл ажиллагаа 3: Багууд бие биендээ мэдээллээ танилцуулсны дараа Гэр бүлийн шалгах хуудсыг тараан өгч бөглүүлээрэй. Дараа нь энэ хуудсыг эцэг, эхдээ өгч бөглүүлээд гэр бүлээ газар хөдлөлтөөс хамгаалах аргад суралцуулаарай.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх алхмууд, гэр бүлийн шалгах хуудас.

СЭДЭВ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

Тулгуур ойлголт: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өөрийгөө авч явах боломжгүй, хөдөлгөөн хязгаарлагдмал, хэлж ойлгуулах, тусламж хүсэх чадвар хомс байдгаас онцгой халамж анхаарал шаарддаг. Иймээс тэдний энэ нөхцөл байдлыг сайн ойлгож, гамшгаас хамгаалах бүхий л үйл ажиллагааг явуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн тусламж үйлчилгээг тусгайлан төлөвлөж, зохион байгуулах хэрэгтэй.





Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах онцлог:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд илүү их анхаарал, халамж шаарддаг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүртгэлд хамрагдахгүй хоцрох, үүнээс үүдэн хэрэгцээт үндсэн үйлчилгээг авч чадахгүй хоцрох
- Аливаа үйлчилгээ, тусламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүргэх төлөвлөгөөг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгайлан тусгах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлтөд анхнаас нь оруулж, тэдгээрт шаардлагатай мэдлэг, мэдээллийг өгөх
- Эдгээр хүүхдүүд бүрэн эрхээ эдлэх, гадуурхагдан хавчигдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахдаа зайлшгүй харгалзах зүйл:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, эрүүл ахуйн асуудал: гар угаалтуур, жорлон, усны онгоц зэрэг хэрэгцээт зүйлс нь эдгээрт зориулагдан хийгдсэн, ашиглахад хялбар, загвартай байх ёстой
- Хүнс, хоол тэжээлийн асуудал: хангалттай чанартай, аюулгүй байдлыг хангасан хүнс бэлтгэх, хоолны хэрэгсэл тэднийг хооллоход тохиромжтой байх нь чухал
- Байр, сууцны асуудал: ашиглах байр нь дээд зэргийн аюулгүй байдлыг хангасан байх, хувцас, орны хэрэгсэл, ахуйн хэрэглээний зүйлүүд нь хэрэглэхэд хялбар, энгийн байх хэрэгтэй

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1:Хичээлийн эхэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж хэнийг хэлэх вэ? гэсэн асуулт тавина. Эндээс харах, сонсох, хөдөлгөөн хязгаарлагдмал, оюуны бэрхшээлтэй иргэнийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэж нэрлэдэг гэсэн дүгнэлтэнд хүргэнэ.

Үйл ажиллагаа 2:Бүлгийн гишүүдийг 3 багт хуваана. Баг тус бүр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гамшгийн өмнө юуг бэтгэсэн байх ёстойг багаараа ярилцаад жагсаалт гаргахыг хүснэ. Баг бүрийн гаргасан жагсаалтыг сонссоны дараа сурагчийн номны мэдээлэлтэй харьцуулах даалгавар өгч юуг дутуу орхигдуулсан талаар ярилцаарай.

Үйл ажиллагаа 3:Дараа нь эхний баг сонсголын, дараагийн баг харааны, 3 дахь баг хөдөлгөөны бэрхшээлтэй иргэдэд зориулсан зөвлөмж бичээд сургуулийн хананд өлгөх даалгавар өгөөрэй.

Хичээлийн хэрэглэгдэхүүн:Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг таних шинж тэмдэг бүхий зурагнууд. Том цаас, маркер.





СЭДЭВ 10. ГАМШГИЙН ҮЕ ДЭХ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ



Тулгуур ойлголт: Гамшгийн үед хүүхдэд учрах олон тооны хохирол, хүндрэл бэрхшээлээс хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэн чухал 4 чиглэл байдаг.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: бүлгийн гишүүдийг 2 багт хувааж 1-р багт гамшгийн үед хүүхдэд ямар, ямар хохирол, хүндрэл бэрхшээл учирч болох талаар жагсаалт гаргахыг хүснэ. 2-р багт гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хүүхдээ хамгаалах чиглэлээр ямар, ямар ажлыг хийж болох талаар ярилцаад жагсаалт гаргахыг хүснэ. Багууд мэдээллээ солилцсоны дараа сурах бичгийн мэдээлэлтэй танилцаж нэмэлт мэдээлэл авна

Үйл ажиллагаа 2: Хүүхдүүдийг 6-8 багт хувааж манай оронд тохиолдож болох гамшгийн төрөл бүр дээр хүүхдэд нөлөөлж болох хохирол, хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, бид ямар хамгааллын ажлыг хийж чадах талаар танилцуулга хийн найз нөхөддөө танилцуулж, төгсгөлд **“Бид бие биенийгээ аварч чадна”** сэдэвтэй ханын сонин хийж бусдадаа энэ мэдээллийг дамжуулаарай.

Гамшгийн үед хүүхдэд учрах нийтлэг хохирол, хүндрэл бэрхшээлээс гадна гамшгийн төрөл тус бүр хүүхдэд дараах байдлаар нөлөөлж болох юм.

Газар хөдлөлтийн үед хүүхдэд:	Үерийн үед хүүхдэд:
<ul style="list-style-type: none"> • дарагдаж, гэмтэж бэртэх • төөрөх, бусад санамсаргүй болон санаатай байдлаар эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлээсээ тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх • халдварт өвчин тархаж, түүгээр өвчлөх • хорт бодист хордох, угаартах, түлэгдэх, амьсгал боогдох • орон гэр эд хогшил нь эвдэрч, эдийн засгийн хохирол амсах • нийгэм, сэтгэлзүйн хямрал, цочролд орох • үл хайхрагдах • дарамт хүчирхийлэлд өртөх • амь насаа алдах зэрэг 	<ul style="list-style-type: none"> • гэмтэж бэртэх • урсах • живэх • орон гэр, эд хогшлоо алдаж эдийн засгийн хохирол амсах • төөрөх, бусад санамсаргүй болон санаатай байдлаар эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлээсээ тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх • нийгэм, сэтгэлзүйн хямрал, цочролд орох • үл хайхрагдах • дарамт хүчирхийлэлд өртөх • амь насаа алдах зэрэг





<p>Хүчтэй салхи, шуурганы үед хүүхдэд:</p> <ul style="list-style-type: none"> • төөрөх, бусад санамсаргүй болон санаатай байдлаар эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлээсээ тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх • даарах, осгох • орон гэр эд хогшил нь эвдэрч, эдийн засгийн хохирол амсах • нийгэм, сэтгэлзүйн хямрал, цочролд орох • дарагдаж, гэмтэж бэртэх • хөлдөх • үл хайхрагдах • дарамт хүчирхийлэлд өртөх • амь насаа алдах зэрэг 	<p>Гал түймрийн үед хүүхдэд:</p> <ul style="list-style-type: none"> • түлэгдэх • амьсгал боогдох • угаартах • төөрөх, бусад санамсаргүй болон санаатай байдлаар эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлээсээ тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх • орон гэр эд хогшил нь эвдэрч, эдийн засгийн хохирол амсах • нийгэм, сэтгэлзүйн хямрал, цочролд орох • үл хайхрагдах • дарамт хүчирхийлэлд өртөх • амь насаа алдах зэрэг
<p>Ган тохиолдсон үед хүүхдэд:</p> <ul style="list-style-type: none"> • наранд цохиулах • усны хомсдолд орох • бие муудах, ухаан алдах • халдварт өвчинд нэрвэгдэх • мал, амьтан нь хорогдож эдийн засгийн хохирол амсах • дайжих, нүүх явцад төөрөх, санамсаргүй болон санаатай байдлаар эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлээсээ тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх • нийгэм, сэтгэлзүйн хямрал, цочролд орох • үл хайхрагдах • дарамт хүчирхийлэлд өртөх • мөлжлөгийн золиос болох • амь насаа алдах зэрэг 	<p>Зудын үед хүүхдэд:</p> <ul style="list-style-type: none"> • даарах, осгох • хөлдөх • санамсаргүй болон санаатай байдлаар эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлээсээ тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх • мал, амьтан нь хорогдож эдийн засгийн хохирол амсах • өвчин тусах • нийгэм, сэтгэлзүйн хямрал, цочролд орох • үл хайхрагдах • дарамт хүчирхийлэлд өртөх • мөлжлөгийн золиос болох • амь насаа алдах зэрэг
<p>Техникийн холбогдолтой ослын үед хүүхдэд:</p> <ul style="list-style-type: none"> • амь насаа алдах • хөгжлийн бэрхшээлтэй болох • эцэг эх, асран хамгаалагчаасаа салах, өнчрөх зэрэг 	<p>Химийн аюултай болон хортой бодисын ослын үед хүүхдэд:</p> <ul style="list-style-type: none"> • амь насаа алдах • өвчлөх • хордох • түлэгдэх • амьсгал боогдох • эцэг эх, асран хамгаалагчаасаа салах, халамж хамгаалалгүй үлдэх зэрэг







ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ӨСВӨРИЙН АВРАГЧ БҮЛЭГТ ГАМШГААС
ХАМГААЛАХ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА: АХИСАН ТҮВШИН





СЭДЭВ 1: ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Тулгуур ойлголт: Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнөх, гамшгийн үеийн, гамшгийн дараах гэсэн 3 үе шаттайг ойлгуулах.

Хэрвээ бид байгалийн үзэгдэл нь яагаад тохиолддогийг ойлгож мэдэх, бид юу хийвэл түүнд өртөж хохирол амсахгүй байх талаар илүү сайн ойлголттой болвол гамшиг болохоос урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Хүмүүс бид аливаа гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа тодорхой зүйлийг хийж байж гамшгаас өөрсдийгөө хамгаалах, аливаа аюул ослыг хохирол багатай даван туулна.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: сурагчийн номонд өгөгдсөн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг харуулсан зургийг харуулна. Зургаас гамшиг болохоос өмнө урьдчилан сэргийлэх боломжтой гэсэн дүгнэлтэнд хүргэнэ.

Үйл ажиллагаа 2: бүлгийн сурагчдыг 4 багт хуваана.

1-р баг гамшгаас урьдчилан сэргийлэх, 2-р баг гамшгийн үед эрэн хайх-аврах, 3-р баг гамшгийн дараах буюу хор уршгийг арилгах, 4-р баг сэргээн босгох багуудад хуваана. Дараа нь сурагчийн гарын авлагад өгсөн хүснэгттэй танилцаж дэс дараалан бусад багийнхандаа танилцуулах даалгавар өгнө. Төгсгөлд нь Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь 4 үе шаттай явагддаг гэсэн дүгнэлтэнд хүрнэ.

Үйл ажиллагаа 3: Хичээлийн төгсгөлд “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” тоглоомыг тоглоно.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: үзүүлэн, хүүхдийн номын 4-р хавсралтад үзүүлсэн Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бүрдүүлэгч арга хэмжээнүүдийг нэг нэгээр нь бичсэн 18 картыг багийн тоогоор бэлтгэх, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ”, “АВРАХ”, “ХОР УРШГИЙГ АРИЛГАХ”, СЭРГЭЭН БОСГОХ” гэсэн үг бичсэн 4 цаас



СЭДЭВ 2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ТУХАЙ



Тулгуур ойлголт: “Гамшгийн эрсдэл нь болзошгүй аюулт үзэгдэл, ослын улмаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлал” юм.

“Эмзэг байдал нь болзошгүй гамшгийн аюулд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөж хохирох зэрэг” юм.

Эрсдэлийн үнэлгээг яаж хийх вэ?

Эрсдэл нь тодорхой аюулаас тодорхой цаг хугацаанд, тодорхой газар нутагт хүний амь, эрүүл мэнд, өмч хөрөнгө, амьжиргаа, аж ахуйн үйл ажиллагаанд хохирол учрах магадлал байдаг. Энэ магадлал ямар байгааг тодорхой хэмжээгээр тооцож болдог. Үүнийг **ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ** гэнэ.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь болзошгүй аюулыг шинжиж, дүгнэснээр түүний хүмүүс, эд хөрөнгө, байгаль орчинд гарз хохирол учруулж болохуйц





эмзэг байдал мөн үүнийг даван гарч чадахуйц чадвартай байдлыг тодорхойлох үйл ажиллагаа юм.

Гамшгийн эрсдэлийг юу нэмэгдүүлдэг вэ?

- Байгалийн аюултай үзэгдлийн тохиолдох давтамж нэмэгдвэл
- Уур амьсгалын өөрчлөлт
- Байгаль орчны доройтол
- Хүн амын хэт их өсөлт
- Төлөвлөлт муутай хотжилт
- Техник, технологийн өндөр хөгжил
- Хүмүүсийн аливаа аюулд бэлэн байдлаа хангах, давж гарах чадвар султай байх
- Ядуурал
- Хүмүүсийн хүлцэнгүй идэвхгүй байдал

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1:Хичээлийн эхэнд дараах асуултыг тавина.

Аюул гэж юу вэ? юуг аюул гэх вэ? Эмзэг байдал гэж юу вэ? эдгээр асуултуудад тодорхой хэмжээний хариулт авсаны дараа доорх зургийг харуулаад дараах асуултыг тавина.

Бид эрсдэлээ бууруулахын тулд юу хийж чадах вэ?

Дал модны жимс бол хүүхдийн хувьд АЮУЛ юм

Хүүхдүүдээ энэ зурагт аюул, эмзэг байдал нь аль вэ?



Дал модны доор хэвтэж байгаа хүүхэд дээр жимс унавал гэмтэх нь ЭРСДЭЛ юм.

Ингээд энэ хүүхэд том жимстэй /аюул/ дал модны доор хэвтсэн /эмзэг байдал/ байгаа нь ЭМЗЭГ БАЙДАЛ юм.

1-рт эрсдэлийн эх үүсвэрийг тогтооно.

2-рт энэ эрсдэлийг бид юу хийвэл арилгах боломжтойг тогтооно.

3-рт хийх боломжтой бүх зүйлийг хийж эрсдэлээ бууруулна.



Аюулыг арилгаж эрсдэлийг байхгүй болгоно.



Аюулаас зайлсхийж эрсдэлийг бууруулна



Аюулын нөлөөллийг багасгаж эрсдэлээ бууруулна

Эрсдэлийг хэрхэн бууруулах

Үйл ажиллагаа 2: Бүлгийн гишүүдийг дээрх зургийг хараад эмзэг байдлыг хэрхэн бууруулж болох талаар зөвлөмж бичихийг хүснэ. Гэрийн даалгаварт орон нутгийнхаа, эсвэл гэрийнхээ эмзэг байдлын талаар эссэ бичих даалгавар өгөөрэй.

Үйл ажиллагаа 3: Хүүхдүүдийн дунд “Гамшгийн эрсдэл” гэсэн сэдвээр ГАР ЗУРГИЙН БОЛОН ЭССЕ БИЧЛЭГИЙН УРАЛДААН зохион байгуулан дүгнэж, бүх уралдаанд ирүүлсэн бүх материалыг сургуулийн нийт сурагчдын дунд дэлгэн харуулна.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: үзүүлэн



СЭДЭВ 3.НЭРВЭГДЭГСДИЙГ АВРАХ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ, ЗӨӨХ АЖИЛЛАГАА



Тулгуур ойлголт: Аврах ажлыг мэргэжлийн баг гүйцэтгэх боловч зарим тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг хүрэлцэн иртэл эсвэл мэргэжлийн баг хүрэлцээгүй үед эхний шатанд нутгийн иргэд, сайн дурынхан, өсвөрийн аврагчдыг боломжийн хирээр татан оролцуулах боломжтойг ойлгуулах.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: өмнөх хичээл дээр үзсэн мэдлэгийг ашиглан шинэ хичээлийн мэдлэгийг өгөхийн тулд нэг сурагч гарч ирэхийг хүснэ. Гарч ирсэн сурагчийг шүүгч хийхийг сануулна. Үлдсэн сурагчдыг 2 багт хуваана. Баг тус бүрээс гарч ирсэн сурагч эрэн хайх, аврах үйл ажиллагааны зорилго, үйл ажиллагаанд хамаарах арга хэмжээг хэлэх даалгавар өгнө. Бүх багуудыг хэлж дууссаны дараа шүүгч сурагч хамгийн зөв, оновчтой хариулсан багийг шалгаруулж дүгнэнэ.

Үйл ажиллагаа 2: Бүлгийн сурагчдыг 4 багт хувааж дараах нэрүүдийг өгнө.

- 1-р баг Нэрвэгдэгсдийг эрэн хайх
- 2-р баг Нэрвэгдэгсдэд заналхийлж буй аюулаас нь чөлөөлөх
- 3-р баг Амилуулах суурь тусламж үзүүлэх
- 4-р баг Аюултай бүсээс зөөж гаргах

Баг тус бүрийг сурагчийн номыг 3 мин уншаад бусад багийнхандаа



тайлбарлах даалгавар өгнө. Баг тус бүр танилцуулсны дараа бүлгийн сурагчдыг дахин багт хуваана.

Үйл ажиллагаа 3: эхний багт амьд эсхийг шалгах, 2-р багт аюултай бүсээс зөөн гаргах, 3-р багт нэрвэгдэгсдийг зөөн гаргах аргуудыг үзүүлэх жүжигчилсэн тоглолт хийх даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 4: Нэрвэгдэгсдийг зөөх буухиа тоглоомыг тоглуулна.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: толь, гар чийдэн, бүтээлэг, олс, 2 урт мод.

СЭДЭВ 4. ӨРХИЙН БА ХУВЬ ХҮНИЙ БЭЛЭН БАЙДЛЫН БАГЦ

Тулгуур ойлголт: гамшгийн үед гэр бүлийн бэлэн байхын ач холбогдлыг ойлгуулах. Хүн нэг бүрийн бэлэн байдлын багц гэж юуг хэлдэг болох, түүнд шаардлагатай зүйлсийг мэддэг болох.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: багш урьдчилан өрхийн бэлэн байдлын багцыг бэлдэж ирнэ /эсвэл зурагт үзүүлэн бэлдэж ирэх/. Ингээд бүлгийн сурагчдыг 5 бүлэгт хуваана. 1-р баг хоол хүнс, 2-р баг эмийн сан, 3-р баг хувцас, 4-р баг холбоо харилцаа, 5-р баг бичиг баримт нэр өгч өөрийн багт хамааралтай эд зүйлсийг сонгон авах даалгавар өгнө. Сонгон авсан эд зүйлсийг гамшгийн үед яагаад хэрэгтэй вэ, ямар үед яаж хэрэглэх талаар тайлбарлах даалгавар өгнө. Эндээс гамшгийн үед өрхийн бэлэн байдлын багц бэлэн байхын ач холбогдлыг тайлбарлуулж дүгнүүлнэ.

Үйл ажиллагаа 2: хүүхдийн номноос хүн нэг бүрийн үүргэвчинд байх ёстой зүйлс, тэдгээрийг гамшгийн үед хэрхэн хэрэглэх аргын талаар уншиж, хамтдаа ярилцана. Эцэст нь хамгийн гол нь бэлтгэсэн хүнсний зүйлсийн хадгалалтын хугацаа, хэзээ дуусах зэргийг мэдэж сайтар шалгах ёстойг сануулна.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: өрхийн бэлэн байдлын багцын цүнх, үүргэвч эсвэл хайрцаг, эм, хоол хүнс, холбоо харилцааны хэрэглэгдэхүүн зэрэг бүхий л зүйл.

СЭДЭВ 5. ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА

Тулгуур ойлголт: Онцгой байдлын алба улс орон, ард иргэдээ болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн зорилготой төрийн байгууллага юм.

“БИД ХАМГААЛНА, АВАРНА, ТУСАЛНА” гэсэн уриатай иргэдээ гамшгаас хамгаалах үүргээ нэр төртэй гүйцэтгэсээр ирсэн хамт олон.





Онцгой байдлын албаны үндсэн чиг үүрэг

Төрийн бодлого, хууль тогтоомж,
Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх

Гамшгаас хамгаалах бүх шатны
байгууллагуудыг шинэчлэн байгуулах,
тэдгээрийн эрх зүйн орчныг бүрдүүлэх

Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг
чанартай, үр өгөөжтэй, хурдан шуурхай
хүргэх

- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх
- Аврах
- Учирсан хор уршгийг арилгах
- Сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Энэ хичээлийг тухайн орон нутагт байгаа онцгой байдлын газар, хэлтсүүдийн мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй. Учир нь тэдний ажил, мэргэжлийн онцлог, багаж, техник хэрэгсэлтэй биечлэн үзэж танилцах нь Өсвөрийн аврагчдыг мэргэжлийн чиг баримжаагаа олж авах, тэднээр бахархах олон талын ач холбогдолтой.

Үйл ажиллагаа 2: бүлгийн гишүүд мэдээллийн хэрэгсэл /телевиз, сонин, сэтгүүл, интернэт гэх мэт/ болон номноос онцгой байдлын албаны талаар мэдээлэл цуглуулан танилцуулга бэлтгэж мэдээллээ бусдадаа хуваалцах гэрийн даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 3: Сургуулийн нийт хүүхдүүдийн дунд “Миний мэдэх онцгой байдлын алба” гар зургийн болон эссе бичлэгийн уралдаан зарлаж дүгнэнэ. Амжилттай оролцсон хүүхдийг онцгой байдлын албаны мэдээллийн цагаар сурталчилна.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: онцгой байдлын албан үйл ажиллагааг харуулсан төрөл бүрийн фото зураг, сонин сэтгүүлийн мэдээ, хайчилбар



СЭДЭВ 6. АВРАГЧ, ГАЛ СӨНӨӨГЧ МЭРГЭЖИЛ

Тулгуур ойлголт: Аврагчид гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод шуурхай шилжин байрлаж, эрэн хайх, аврах ажлыг явуулах, нэрвэгдэгсдэд бүх төрлийн яаралтай тусламж үзүүлэх, тэднийг аюулгүй газарт зөөвөрлөн гаргах, эд хөрөнгийг хамгаалах үүрэг гүйцэтгэдэг.

Онцгой байдлын албанд аврагч, гал сөнөөгч, шүхэрчин- аврагч, десантчин- аврагч, аврагч-усчин, аврагч-химичин, аврагч-холбоочин, аврагч-тэсэлгээчин, аврагч-жолооч зэрэг төрөл мэргэжлийн аврагч үүрэг гүйцэтгэдэг.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Багш сурагчийн номонд тавигдсан мэргэжлүүдийн зургийг үзүүлж нэрлүүлэх дасгал хийлгэнэ. Ихэвчлэн нэршил хольж нэрлэх нь гарцаагүй иймээс дараа нь сурах бичгийг харуулан хэрхэн зөв нэрлэсэн болохыг дүгнүүлнэ. Аль мэргэжил нь чамд таалагдсан бэ? Яагаад гэдэг асуултыг тавиаарай.





Үйл ажиллагаа 2: Дараа нь эдгээр аврагчид аврах ажиллагаандаа ямар багаж хэрэгсэл ашигладаг тухай асууж ярилцаад багаж, хувцас хэрэгслийн зургийг харуулж, нэрлүүлээд, ямар үед хэрхэн ашиглаж болох талаар ярилцаарай.

Үйл ажиллагаа 3: Аврах, гал унтраах ангитай танилцах аялал хийх. Аврах ажиллагааны болон шуурхай албаны автомашин багаж хэрэгсэл, байлдааны хувцас, гал сөнөөгчийн хувийн багаж хэрэгсэл, гал унтраах үйл ажиллагаа зэрэгтэй танилцана.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: гал сөнөөгч, шүхэрчин- аврагч, десантчин-аврагч, аврагч-усчин, аврагч-химичин, аврагч-холбоочин, аврагч-тэсэлгээчний зураг.

Хичээлийг боломжтой бол аврах, гал унтраах ангийн сургалтын танхим, гадна сургалтын талбайд мэргэжлийн аврагч нартай хамтарч явуулбал үр дүнтэй болно.



СЭДЭВ 7. ГАЛ УНТРААХ АНХАН ШАТНЫ БАГАЖ ХЭРЭГСЭЛ, ГАЛ УНТРААГУУРЫГ АШИГЛАХ АРГА

Тулгуур ойлголт: Гал гарсан тохиолдолд “түргэн тусламж” маягаар ямар ч хүн ажиллуулан галын анхны эх үүсвэрийг унтраах боломжтой зөөврийн багаж хэрэгслийг гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл гэнэ.

Хамгийн түгээмэл хэрэглэгддэг анхан шатны багаж хэрэгсэл бол гал унтраагуур (галын хор) юм. **Гал унтраагуур** гэдэг нь гал унтраах бодисыг галын голомт руу цацсанаар галын дөлийг дарах, галыг агаар (хүчилтөрөгч)-аас тусгаарлах замаар галыг бага дээр нь түргэн унтраах зориулалттай зөөврийн ба хөдөлгөөнт төхөөрөмж юм.



Ахуйн хүрээнд хамгийн түгээмэл хэрэглэгддэг зөөврийн гал унтраагуур нь (20 кг-аас бага хэмжээтэй) цилиндр хэлбэрийн металл сав, шүрших хоолой, бариул, гал унтраах бодис дамжих хоолойтой байдаг.

Гал унтраагуурыг хэрэглэх аргачлал:

- Ямар ангиллын галын төрөлд тохирохыг шалгана.
- Аюулгүйн лацыг салгаж, түгжээг мулталж авна.
- Нэмэлт даралттай гал унтраагуурын хувьд гал унтраах уян хоолойгоо галын голомт руу чиглүүлэн шахуурга буюу ажиллагаанд оруулах гохыг ажиллуулах бариулыг атгана.
- Галын голомтоос тохирох зайтай зогсон шүрших бариулыг хөнгөн атган галын дөл рүү шүршинэ.

Гал унтраах үед галаас хэр зайтай зогсох нь галын төрөл болоод гал унтраах бодисын найрлагаас хамаарна. Үүнд:

- Усаар шүршиж байгаа бол – 2-3 метрт
- Нунтаг гал унтраагуур ашиглаж байгаа бол - 3-4 метрт
- Хийн гал унтраагуур ашиглаж байгаа бол – 1 метрийн зайтай зогсоно.
- Хийн гал унтраагуурыг хувцасанд нь гал авалцсан хүмүүст хэрэглэхийг хориглоно. Учир нь хийн гал унтраагуур -78°C –ийн хүйтэн хийгээр үлээх





тул хүний амь насанд аюултай.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: энэ хичээлийг орон нутгийнхаа мэргэжлийн байгууллага юмуу, сургуулийнхаа гал унтраах хэрэгслүүдийг ашиглан явуулж болно. Эсвэл сурах бичгийн зургийг ашиглаарай. Зураг ашиглахдаа багаж бүрийг нэрлүүлээд ямар үүрэгтэйг нь асууж ярилцана.

Үйл ажиллагаа 2: галын хорыг хэрхэн хэрэглэх зургийг тус тусад 4 хэсэг болгон хайчлаад зөв байрлуулах даалгавар өгнө. Дараа нь зөв байрлуулсан эсэхийг сурах бичгээсээ харна. Боломжтой бол зөөврийн галын хор бэлтгэн, түүнийг хэрхэн ашиглах дарааллыг орон нутгийнхаа онцгой байдлын нэгжтэй холбогдон мэргэжлийн хүний тусламжтайгаар тайлбарлаж өгнө.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: зөөврийн галын хор, эсвэл галын хорыг хэрэглэх дарааллыг харуулсан зургийг урьдчилж олшруулан бэлтгэх



СЭДЭВ 8. ГАЛ ТҮЙМРИЙН ҮЕД АМЬ НАСАА ХАМГААЛАХ АРГА, ТҮЛЭГДЭЛТЭНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ

Тулгуур ойлголт: Гал түймрийн үед амь насаа хамгаалах аргуудыг хүн бүр мэддэг байх нь чухал. Гал түймэр бүрт тухайн шатаж байгаа эд зүйлийн шинж чанараас хамаараад өөр өөрийн онцлогтой шаталт явагддаг ч бүх төрлийн шаталтын дүнд хүний амь насанд аюултай хортой хий ялгардаг. Гал түймрийн улмаас угаартсан хүмүүсийн тоо түлэгдсэн хүмүүсийнхээс 2-3 дахин их байдаг байна. Гал гарч байх үед агаар дахь хүчилтөрөгч багасан амь насанд аюултай хортой хий ихээр ялгардаг. Үүгээр амьсгалсан хүн 1 минутын дотор л үхэлд хүрэх аюултай байдаг.



Гал түймрийн үед үүсэх хортой хийнээс амь насаа хамгаалахын тулд гэрийнхээ дотор, гэрийн гадна болон анги танхим, сургуульдаа утаа мэдрэгч суурилуулж болох юм. Энэхүү дохиогоор хэрхэн ажиллах дасгал сургуулийг хийж, хүн болгон мэдсэн байх нь чухал. Нийт гал түймрийн улмаас нас барсан хүмүүсээс гэртээ утаа мэдрэгчгүй байгаад амиа алдсан хүмүүсийн тоо утаа мэдрэгчтэй байснаасаа 2 дахин илүү байдаг байна.

Галын утаа нь нүд хорсгож, амьсгал боогдуулж ухаан алдуулдаг. Гал түймрийн үед айж сандарсан, үзэгдэх орчин хязгаарлагдмал болсон үед хүмүүс гарах гарцаа олохгүй хувцасны шүүгээ, шатны хонгил, угаалгын өрөөнд нуугдаж амь насаа алдах тохиолдол гардаг. Иймд гал түймрийн үед гарах нэмэлт гарцыг заавал төлөвлөх хэрэгтэй.

Гал түймрийн үед хүний амь насанд аюул учруулах өөр нэг аюул нь түлэгдэх юм. Хүний биеийн аль нэг хэсэг галын дөл, халуун шингэн, халуун уур, улайтсан төмөр зэргийн нөлөөгөөр арьс болон арьсан доорх өөхөн эд, эрхтэн гэмтэхийг түлэгдэлт гэнэ. Гэртээ болон анги танхимдаа ажиллагаатай гал унтраагуур бэлэн байлгаж, түүнийг хэрхэн ашиглахыг хүн бүр мэддэг байх нь гал түймрээс амь насаа хамгаалахад туслах болно.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Бүлгийн сурагчдыг 3 багт хуваана. 1-р багт Гал түймрийн үед өрөөнөөс гарч болох хувилбар, 2-р багт Гал түймрийн үед өрөөнөөс гарч



болохгүй хувилбар, 3-р багт хэрэв таны хувцас галд автсан үед ямар арга хэмжээ авах талаар сурах бичгийн мэдээлэлтэй танилцаж бусад багийнхандаа тайлбарлахыг хүснэ.

Үйл ажиллагаа 2: Дараагийн үйл ажиллагаа бол түлэгдэлтийн зэргийг тодорхойлж сурах мөн тэдгээрт анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварт сургана. Ингэхийн тулд 1-р багын 4 гишүүний гарыг сурагчийн номны зургийг хараад өнгийн харандаа, эсвэл пламастер ашиглан түлэгдэлтийн зэргийг харагдахуйц ойлгомжтой байдлаар зурахыг хүснэ. 2-р баг түлэгдэлтийн зэргийг уншаад 1-р багын гишүүдийн гарны түлэгдэлтийг тодорхойлох, 3-р баг тэдгээрт анхны тусламж үзүүлэх мэдээллийг унших даалгавар өгнө. 1-р баг будаж дууссаны дараа 2-р баг түлэгдэлтийн зэргийг тодорхойлж өгнө. Зөв тодорхойлж байгаа эсэхийг багш болон бүлгийн гишүүд өөрсдөө хянана. Дараа нь 3-р багын гишүүд анхны тусламжыг үзүүлнэ. Аль баг хамгийн сайн байсныг багш үнэлнэ.

Үйл ажиллагаа 3:Хичээлийн төгсгөлд “Яагаад гэвэл ... Яагаад” тоглоомыг тоглуулаарай.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: өнгийн харандаа эсвэл пламастер, уруулын будаг.

СЭДЭВ 9. ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, УНТРААХ АРГА

Тулгуур ойлголт: Ой хээрийн түймрийг гарч байгаа эхний үед унтраах нь хамгийн хялбар. Ой, хээрийн түймэр гарч эхлэх, тархах, дэлгэрч томрох нь үндсэндээ газрын гадаргуугийн налуу, ургамлын, цаг уурын болон бусад нөхцөлүүдээс хамаардаг. Эдгээр хүчин зүйлүүдийг зайлшгүй тооцоолсны үндсэн дээр унтраах ажлыг хамгийн зөвөөр зохион байгуулж, түймэр унтраах ажилд оролцож байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангана.

Ялангуяа түймрийн байдалд нөлөөлдөг шатлагийн процессийн нөхцөл ба түүний эрчим (тархалтын хурд нэмэгдэх), түймрийн чиглэл зэрэг гол хүчин зүйлүүдийг мэдэж байх нь онцгой чухал юм.

Түймрийн тархалтад шатах материалын төрөл, тоо, хэмжээ чухал нөлөөтэй. Хуурай өвс, хатсан навч, жижиг мөчрүүд, сөөг нь хялбархан шатдаг бол мод, хөвд, сөөг зэрэг нь удаан шатдаг.

Цаг агаарын нөхцөл түймэр унтраахад нэн чухал. Хур тунадас бороо орох, эсвэл ихээхэн чийгшилтэй үед түймэр амархан унтардаг. Харин их халуун, хүчтэй салхитай үед маш хялбархан тархдаг.

Түймэр унтраах ажлын үед шатах материал, салхи, чийглэг, агаарын температур, газар нутгийн бартаа, налуу зэргийг зайлшгүй тооцож үзэх шаардлагатай.

Ой, хээрийн түймрийг унтраах ажил нь түймрийн шатлагын үе шат ямар байгаагаас хамаарч янз бүр байна.

Шөнийн цагаар шатах материалууд чийгийг шингээн авдаг, шөнө сэрүүн агаартай болдог зэрэг нь түймэр унтрааж байгаа хүмүүсийн ажлыг хөнгөвчилж өгдөг. Гэхдээ хоногийн гэрэлтэй үед түймэр унтраах ажлыг явуулах нь илүү хялбар юм.





Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1:Бүлгийн сурагчдыг 3 багт хуваана. 1-р багт Ой, хээрийн түймрээс эд хөрөнгөө хэрхэн хамгаалах вэ?, 2-р багт ой, хээрийн түймрийн үед хэрхэн амь насаа аврах вэ?, 3-р багт Ой хээрийн түймрийг унтраах аргуудын тухай мэдээллийг сурах бичгээс уншаад бусад багийнхандаа мэдээлэх даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 2:Хичээлийн төгсгөлд “Гал унтраах буухиа тэмцээн” явуулаарай.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: сурагчийн ном

СЭДЭВ 10. ЗУДЫН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА



Тулгуур ойлголт: Мал сүрэг өвөл, хаврын улиралд бэлчээр, усаар гачигдаж эцэж туран үй олноор хорогдох уур амьсгал, цаг уурын нөхцөлийг зуд гэнэ.

Бүлгийн хүүхдүүд зуд болох хүчин зүйлс, зудын эрсдэлийг хэрхэн бууруулах арга замын талаар мэдлэгтэй болно.

Бэлчээрийн мал аж ахуйн хувьд өвөл, хаврын улиралд их цас, хүйтнээс болж мал сүрэг өлгүйдэж, үй олноороо хорогдон малчдын амьдралд үлэмж хохирол учруулах байгалийн аюултай үзэгдлийг малчид зуд гэж нэрлэж заншсан.



Зуд нь дотроо 5 төрөлтэй байна

Цагаан зуд	Их хэмжээний цас орж бэлчээр цасаар хучигдсанаас мал бэлчээрээс өвс олж идэх боломжгүй болж олноор хорогдох нөхцөлийг хэлнэ
Шуурган зуд	Шуурга удаан хугацаагаар үргэлжилж мал бэлчээрт идээшлэх боломжийг алдагдуулснаас мал бэлчээрлэж чадахгүй, өлсөж даарч олноор үхэх нөхцөлийг хэлнэ
Хүйтний зуд	Мал бэлчээрлэж чадахгүй болтол олон хоногоор хүйтэрч, тэжээл хашаа дутагдсанаас бэлчээрийн мал өлсөж, даарч олноор үхэх нөхцөлийг хэлнэ
Харын зуд	Удаан хугацаагаар цас ороогүй бөгөөд нуур, ихэнх гол, булгийн ус хөлдсөнөөс хурдгийн ус хүрэлцэхгүй мал сүрэг усаар гачигдаж олноор үхэх нөхцөлийг хэлнэ
Туурайн зуд	Өвөлжилтийн байдал хүндэрсэн үед тухайн нутагт гадны аймаг, сумдаас олон мал орж ирснээс бэлчээрийн даац хэтэрч бэлчээрийг бүрэн сүйтгэж идэшгүй болгох нөхцөлийг хэлнэ.



Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Бүлгийн сурагчдыг 3 багт хуваана. 1-р багт Зудын нөхцөл үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл, 2-р багт зудын гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд малчид юу анхаарах ёстойг, 3-р багт орон нутгийн засаг захиргаа юу анхаарах ёстой тухай мэдээллийг сурах бичгээс уншаад бусад багийнхандаа мэдээллэх даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 2: дараа нь орон нутгийнхаа зудын цаг хугацааны түүхэн зураглалыг хийх даалгавар өгнө. Энэ зураглалыг хийхэд орон нутгийн мэргэжлийн байгууллагаас мэдээлэл авч дараагийн хичээл дээр мэдээллээ танилцуулах даалгавар өгч болно.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: сурагчийн ном



СЭДЭВ 11. ҮЕРИЙН АЮУЛААС ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

Тулгуур ойлголт: Аадар бороо эсвэл удаан хугацаанд үргэлжилсэн зүс бороо, хайлсан цас, мөсний усны нөлөөгөөр усны түвшин эрс нэмэгдэх, ус эргээсээ халих, голын эрэг орчмын газар, хуурай сайр усанд автахыг үер гэнэ.

Монгол оронд тохиолдох үерийг хур борооны үер, уруйн үер, шар усны үер гэж ангилдаг болох тухай мөн түүнээс урьдчилан сэргийлэх аргуудын талаар мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлнэ.

Хур борооны үер зуны улиралд удаан хугацааны турш үргэлжлэн орсон борооны нөлөөгөөр үүсэх бөгөөд харьцангуй урьдчилан сэргийлэх боломжтой юм. Монгол орны ихэнх голууд дунджаар хэдэн цагаас 20-25 хоног үерлэдэг.

Уруйн үер нь гол төлөв аадар бороо эрчимтэй орсны улмаас үүсдэг асар хүчтэй усны урсгал учир урьдчилан сэргийлэх боломж маш бага. Уруйн үер нь Монгол Алтай, Говь-Алтайн нуруунаас эх авсан голуудад байнга ажиглагддаг. Мөн говийн бүсээр хүчтэй аадар борооны нөлөөгөөр түр урсацтай голууд маш хурдан хугацаанд үерлэж уруйн үер олонтоо тохиолддог. Сүүлийн үед уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр уруйн үерийн давтамж нэмэгдэж байна.

Шар усны үер манай оронд 4,5 дугаар саруудад өвлийн улиралд өндөр ууланд орсон их хэмжээний цас дулаарсны улмаас хайлснаас гол төлөв үүсдэг. Шар усны үер ихэвчлэн Монгол Алтай, Хөвсгөл, Хангайн нурууны ойр орчимд эрчимтэй ажиглагдана.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Бүлгийн сурагчдын дунд танай орон нутагт аль төрлийн үер тохиолдож болзошгүй вэ, яагаад гэсэн хэлэлцүүлэг хийнэ.

Үйл ажиллагаа 2: Дараа нь эхний багт үерийн аюулаас хэрхэн урьдчилан сэргийлэх, 2-р багт үерийн аюулын үед юу хийж болох вэ талаар, 3-р багт үерийн дараагаар юу хийх хэрэгтэй талаар багаараа ярилцаад жагсаалт гаргах даалгавар өгнө. Багууд мэдээллээ танилцуулсны дараа сурагчийн номноос зөв хийсэн эсэхээ дүгнэнэ. Багууд нийлээд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх аргууд сэдэвтэй ханын сонин хийж сургуулийн ханандаа байрлуулаарай.

Үйл ажиллагаа 3: Гэр бүлийн ахмад настай хүмүүстэй ярилцаж үерийн гамшгийн талаарх туршлага, сургамжийг нь сонсож, тэмдэглэл хөтлөн бүлгийн





гишүүддээ танилцуулах даалгавар өгнө.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: сурагчийн ном, том цаас, маркер.



СЭДЭВ 12. ГОЛ МӨРНИЙ УСНЫ ОСОЛ, ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ АРГА

Тулгуур ойлголт: Гол мөрний усны ослын үед хүмүүс усанд живснээс үүдэж амь насаа алддаг. Живэх гэж усанд амьсгалын зам ус буюу шингэн зүйлээр бөглөрөхийг хэлнэ. Живэлтийн шинж тэмдгүүдэд амнаас хөөс гарах, амьсгал ба зүрхний үйл ажиллагаа зогсох, арьс хөхрөх, хүүхэн хараа томрох зэрэг нь орно.

Гол мөрний усны осол нь гол төлөв хүмүүсийн санамсар болгоомжгүй байдлаас шалтгаалдаг тул усанд осолдож амь насаа алдахаас урьдчилан сэргийлэх боломтой гэсэн мэдлэг, хандлагыг төлөвшүүлэх, шаардлагатай тохиолдолд өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, амь насыг аврах, тусламж үзүүлэх чадвартай болно.

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Бүлгийн сурагчдыг 3 багт хуваана. 1-р багт гол мөрний усанд осолдохоос урьдчилан сэргийлэх арга, 2-р багт мөс цөмрөх аюулаас хэрхэн сэргийлэх тухай, 3-р багт живсэн хүнд анхны тусламж үзүүлэх мэдээллийг сурах бичгээс уншаад бусад багийнхандаа мэдээллэх даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 2: Дараа нь багууд нийлж гол мөрний усанд осолдохоос урьдчилан сэргийлэх арга, мөс цөмрөх аюулаас хэрхэн сэргийлэх, живсэн хүнд анхны тусламж үзүүлэх дэд сэдвүүдийн хүрээнд ханын сонин бэлтгэж сургуулийн мэдээллийн самбарт өлгөнө. Мөн “Чи үүнийг мэдэх үү” буланд өгөгдсөн мэдээллийг бас оруулаарай.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: сурагчийн ном, том цаас, маркер.

СЭДЭВ 13. ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АЮУЛААС ХАМГААЛАХ АРГА

Тулгуур ойлголт: Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг **химийн хортой бодис** хэлнэ.

Тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочроогч шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг **химийн аюултай бодис** хэлнэ.

Химийн осол гэдэг нь химийн хорт болон аюултай бодистой холбоотой дүрэм, журам зөрчигдсөний улмаас хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд эвдрэл, сүйрэл учруулахуйц хэмжээгээр химийн бодис алдагдахыг хэлнэ. Химийн ослын үед химийн бохирдолтын бүсийг тогтооно. Химийн бохирдолтын бүс гэдэг нь химийн бодис хүн ам, мал амьтан, хүрээлэн буй орчинд хохирол учруулах аюултай хэмжээтэй тархсан газар орныг хэлнэ.

Одоо дэлхий дээр байгаа химийн бодисын 90 хувь нь хортойд тооцогдоно. Эдгээр химийн бодисуудыг ашиглаж ажил үйлчилгээ явуулдаг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг химийн аюултай объектод хамааруулдаг. Ийм объектод янз





бүрийн шалтгаанаар буюу техникийн аюулгүй байдлын горим зөрчигдсөнөөс, байгалийн гэнэтийн аюулаас үүдэж осол гарч тодорхой хэмжээний хөнөөл учруулж болзошгүй байдаг.

Ахуйн хүрээнд химийн бодийг зүй бус хэрэглэх, асгаж гоожуулсан тохиолдолд аюултай нөхцөл байдал үүснэ. Зарим химийн бодис бага хэмжээгээр хэрэглэхэд аюулгүй байдаг боловч их хэмжээгээр хэрэглэх, тохиромжгүй нөхцөлд хадгалах үед ноцтой аюулыг учруулдаг.

Химийн бодисоор хордох, түлэгдэх үед үзүүлэх тусламж

Хүчил (80%-ийн цууны, давсны хүчил), шүлт (натрийн шүлт, нашатырын спирт)-ээр хордох нь элбэг тохиолдоно. Бие мохбодид хүчил, шүлт нэвтрэнгүүт ам, залгиур амсгалын замын хүчтэй өвдөлт илэрнэ.

Эхний ээлжинд хүчил шүлтээр хордсон хүний амнаас шүлс, салстыг яаралтай зайлуулна. Цайны халбаганд марль буюу амны цаас ороож амны хөндийг цэвэрлэнэ. Үүний дараагаар 2-3 аяга мөстэй хүйтэн ус уулгах хэрэгтэй.

Бусад химийн бодисоор хордсон үед (хлорт устөрөгч, анилины будагч бодисууд) хордсон хүн ухаантай бол эмчийг иртэл ус уулган бөөлжүүлэх хэрэгтэй. Хэрвээ ухаан алдсан бол тухайн хүнийг дэргүйгээр түрүүлэг нь харуулж, толгойг нь аль нэг тийш эргүүлэн хэвтүүлнэ.

Химийн бодисын түлэгдэлт нь түлэх чанартай бодисууд (хүчтэй хүчил, шүлт, хүнд металын давсууд, фосфор) хүний биед нөлөөлсний улмаас эд эрхтний үхжилтийг бий болгодог. Химийн бодисын түлэгдэлтийн үед химийн бодис шингэсэн хувцасыг яаралтай тайлна. Арьсыг их хэмжээний цэвэр усаар угаана. Өвчин намдаах эм уулган эмнэлгийн байгууллагад хүргэнэ.


Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1:Хичээлийн эхэнд гэрийн нөхцөлд хэрэглэдэг ямар ямар химийн бодис агуулсан бүтээгдэхүүнүүдийг мэдэх вэ? гэсэн асуулт тавина. Угаалгын нунтаг, угаалгын шингэн, том, жижиг, цэнэглэгч /батарей/, шавьж устгагч хор зэрэг бүтээгдэхүүнүүдийг нэрлүүлнэ. Багш нэрлэсэн нэрүүдийг самбарт бичнэ. Дараа нь эдгээр бүтээгдэхүүнүүд амьд биед хэрхэн нөлөөлж болох талаар ярилцана.

Үйл ажиллагаа 2:Химийн аюултай болон хортой бодисын аюулд өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай, гэр, сургуулийн ойр орчимд осол болсон үед хэрхэн ажиллах талаар, ахуйн хүрээнд ашигладаг химийн бодисын аюулаас хэрхэн сэргийлэх талаар уншаад харилцан ярилцах даалгавар өгнө. Ингээд танай орон нутаг химийн бодис ашиглан үйлдвэрлэл явуулдаг ямар ямар байгууллагууд байдаг талаар ярилцаарай.

Үйл ажиллагаа 3:Багш химийн аюултай бодис бүхий бүтээгдэхүүнийг тэмдэглэсэн тэмдэглэгээг нэг нэгээр харуулж ямар утга санааг агуулсан болохыг асууна. Сурагчид ихэвчлэн хариулж чадахгүй тул сурагчийн номтой ажиллуулаарай. Дараа нь химийн аюултай бодис бүхий бүтээгдэхүүнүүдийг харуулж зөв нэрлүүлээрэй.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: Химийн аюултай бодис бүхий бүтээгдэхүүний зураг. Ахуйн хэрэглээний бодисын зураг. Сурагчийн ном.





СЭДЭВ 14. ТӨӨРСӨН ҮЕД ӨӨРИЙГӨӨ АВРАХ АРГА



Тулгуур ойлголт: Төөрсөн үед соронзон орон, одон орон, газар орны шинж тэмдгээр зүг чигээ тодорхойлох, шаардлагатай тохиолдолд аюул, ослын дохио өгөх мэдлэг, чадвартай болно.



Төөрсөн тохиолдолд өөрийнхөө байрлалыг зөв тодорхойлох хэрэгтэй. Өөрийнхөө байрлалыг зөв тодорхойлохын тулд явсан мөрөөрөө буцан сайн мэддэг газраа очиж зүг чигээ олох нь чухал. Эсвэл өндөрлөг газарт гарч эргэн тойрондоо байгаа тодорхой тэмдэгтүүд (гол нуур, уул, даваа гэх мэт) тэдгээрийн хоорондын зайг тодорхойлон, цаашид явах зүг чиг, замаа тодорхойлох хэрэгтэй.

Төөрсөн үедээ явах чиглэлээ алдалгүй барих нь нэг газартаа тойрон эргэлдэхээс сэргийлнэ. Хүний зүүн хөлний алхам баруун хөлний алхамаас 0.1-0.4 мм урт байдагтай холбоотойгоор туршлагагүй хүн зөв чигт явж байна гэж бодсоор улам бүр баруун гар тийш хазайсаар анх хөдөлсөн тэр газраа эргээд ирдэг байна. Иймд луужингаа ашиглан чиглэлээ сайн тодорхойлох шаардлагатай луужингүй тохиолдолд чиглэлээсээ хазайхгүйн тулд нар, сарны байрлалаар явах зүгээ хянах хэрэгтэй. Түүнчлэн газар орны байдлыг сайн ажиглаж тодорхой содон тэмдэгтэй газрыг сонгон авч тэдгээрийн зайг харьцуулан баримжаалж явах нь зүйтэй.

Аливаа аялалд явахдаа луужин, байр зүйн зурагтай явах хэрэгтэй. Луужин ашиглан хойд зүгийг хялбархан тодорхойлж болно. Луужингаар зүг чигээ тодорхойлохын тулд луужингаа тэгш барьж зүүг хязгаарлагч чагтаар суллаж чөлөөтэй эргэлдүүлж тогтооно Луужингийн их биеийг зөөлөн эргүүлж, зүүний үзүүрийг N үсэгтэй давхцахад

- N-north (С-север)-хойт
- S-south (Ю-юг) –өмнөд
- E-east (В-восток)– зүүн
- W- west (З-запад) – баруун зүгийг заана.

Луужингаар зүг чиг тодорхойлохдоо дараах зүйлийг анхаараарай

- Автомашинаас 5 метрээс багагүй зайд зогсох хэрэгтэй
- Гартаа төмөр зүйл барьсан байж болохгүй
- Луужингаа унагаж гэмтээхээс болгоомжлох хэрэгтэй

Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1:Хичээлийн эхэнд багш чи хэрвээ төөрвөл яах ёстой вэ? гэсэн асуултаар хичээлээ эхэлнэ. Сурагчид газарзүй, физикийн хичээлд үзсэн мэдлэгээ ашиглан долоон бурхан одоор, луужингаар зүг чигээ олж болно гэж хариулах байх. Энэ хариултыг ашиглан дараагийн үйл ажиллагаандаа шилжээрэй.

Үйл ажиллагаа 2:Бүлгийн гишүүдийг 5 багт хувааж эхний багт төөрсөн үед зүг чиг тодорхойлох аргууд, дараагийн багт соронзон орноор зүг чиг тодорхойлох, 3-р багт одон орноор зүг чиг тодорхойлох, 4-р багт газар орны шинж тэмдгээр зүг чиг тодорхойлох, 5-р багт төөрсөн үед аюул, ослын дохиог өгөх аргуудыг уншаад бусдадаа тайлбарлах даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 3: Дараа нь эдгээр аргуудыг мэдэх нь ямар ач холбогдолтой



талаар ярилцаад ханын сонин гаргаж бусадтайгаа мэдлэгээ хуваалцах боломж олгоорой.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: сурах бичиг, том цаас маркер.

СЭДЭВ 15. ТЭСЭЖ АМЬД ҮЛДЭХ АРГА

Тулгуур ойлголт: Хээр, хөдөө болон гамшгийн үед орон байр, хоол хүнсээ өөрсдөө гарын доорх эд зүйлийг ашиглан бэлтгэж нөхцөл байдал хэвийн болох хүртэл амьдрах чадвартай болно.

Түүдэг асаах арга

Түүдэг гал асаахад юуны түрүүнд хэрэг болох хуурай, давирхайтай мөчир, хэсэгхэн хусны үйсийг ойгоос хялбархан олж болно.

Ингээд нарийн мөчир, хусны үйс, хаг өвс зэрэг түүдэг асаахад бэлтгэнэ. Энэ бүх материал аль болох хуурай байж түүдэг маань хурдан асах боломжтой шүү. Навчгүй хуурай мөчир, модыг хагалахдаа нэг үзүүрийг нь салгалгүй үлдээгээд завсар нь хусны үйс, зомгол, хуурай хаг өвс, холтос, жижиг хуурай, навчгүй мөчир зэргийг хийгээд доороос нь асаана. Түүдэг гал хангалттай сайн ассаны дараа удаан асах бүдүүн мод, мөчир нэмнэ. Түүдэг галаа унтраахгүйн тулд галдаа нэмж байгаа мөчир, хагалсан модоо хооронд агаар орох зай завсартай байлгах хэрэгтэй. Түлээгээ галд бага багаар нэмээрэй.

Түүдэг асаахдаа салхигүй нөмөр газрыг сонгож сайтар цэвэрлэнэ. Түүдэг галаа аль болох бага хэмжээтэй асаагаарай. Салхи шуургатай үед хуурай өвс, мөчиртэй гал авалцаж ойн түймэр дэгдэж болзошгүй.

Түүдэг галыг зориулалтаасаа шалтгаалаад дохио өгөх, хоол бэлтгэх, хувцас хатаах, дулаацах гэх мэт хэд хэдэн төрлөөр асаана.

Овоохой: Энэ түүдэгт ямар ч төрлийн мод зохимжтой. Моднуудаа овоохой хэлбэрээр төв рүү чиглүүлэн бие биеийг нь түшүүлэн босгож өрнө. Энэ тохиолдолд модны дээд хэсэг шатах бөгөөд дөл нь тод, өндөр, халуун, халаах зурвас нь хязгаарлагдмал байна. Ийм түүдэгт мод байнга нэмэх хэрэгтэй.

Худаг: Түүдгийн хамгийн түгээмэл төрөл. Урт болон зузаанаараа ижил хэмжээтэй түлээг өрж тавина. Гал асахад 2 түлээг параллелаар тавьж, дараагийн түлээг хөндлөнгөөр нь параллелаар өрнө. Энэ өрөлт галд агаар сайн оруулж өгөх бөгөөд түлээ бүтнээрээ жигд шатна. Ийм түүдэг дөл, дулаан ихээр ялгаруулж, овоохой хэлбэрийн түүдгээс илүү том талбайг халаана. Дохио өгөхөд энэ хэлбэрийн түүдгийг ашиглаж болно.

Түүдгээ унтраахгүй байхаас гадна түймэр алдахгүйн тулд галаа заавал манах хэрэгтэй. Буудалласан газраасаа хөдлөхийн өмнө асаасан түүдэг галаа сайн унтраана. Шаардлагатай бол ус хийж бүрэн унтраагаарай. Бүрэн унтраагаагүй гал ой, хээрийн түймэр гарах нэг том шалтгаан гэдгийг бүү мартаарай.





Түр хоргодох байр барих арга

Төөрсөн, тээврийн хэрэгслийн осолд орсон гэх мэт янз бүрийн нөхцөл байдалд ганцаараа эзгүй газар удаан хугацаагаар үлдэх үед хүчээ гамнах, байгалийн элдэв үзэгдлээс өөрийгөө найдвартай хамгаалах хамгийн энгийн хоргодох, отоглох байр барих шаардлага гардаг. Аврагчдад ганц нэгээрээ яваа, эсвэл бүлгээрээ яваа хүмүүсийг олохоос ийм отгийг олох хамаагүй хялбар юм. Отоглох газар нь хэд хэдэн шаардлага түүний дотор аюулгүй байдлыг хангасан байх нь чухал. Голын эрэг, нам дор газар, хавцал зэрэг газрыг сонгох хэрэггүй. Гэнэтийн бороонд усны түмшин нэмэгдэж усанд автаж болзошгүй. Мөн хад чулуу ихтэй газар, өндөр уулын орой аюултай. Ер нь аюултай газар өвс ургамал бараг байхгүй, магадгүй зулзаган мод байж болох юм. Хүйтэн уур амьсгалтай газар газрын рельефийг тооцох хэрэгтэй. Нам дор газар хүйтэн хургадаг гэдгийг мэдэхэд илүүдэхгүй. Мөн түүнчлэн отоглох газрын ойр өмхөрсөн мод, амьтны үүр, шоргоолжны үүр байх ёсгүй шүү. Зэрлэг амьтны сонирхлыг таны хэрэглэсэн зүйлс, ороох боох материал татаж болзошгүй учир хог хаягдлаа хамаагүй хаяхгүй байхыг зөвлөө.

Дараагийн шаардлага бол отоглох газар ус болон модтой ойролцоо байх нь давуу тал юм. Хэрэв зуны халуун үе бол урсгал ус олох нь маш чухал. Харин хүйтний улиралд бол түлээ болгон ашиглах модтой байх нь чухал.

Хээр талд бол хүйтэн салхинаас хамгаалахыг тулд майхнаа довцог толгодыг нөмөрт босгох нь зүйтэй. Хэрэв цаг агаар дулаан, хуурай, шумуул ихтэй байвал майхнаа өндөрлөг газар, тал талаасаа салхи орж байхаар бодолцоорой.

Говь, цөлд өдөр нь маш халуун харин шөнө хүйтэрч ус хөлдөхөд хүрдэг. Тиймээс ийм газарт халуунаас ч хүйтнээс ч хамгаалах шаардлага тулгарна. байгалын өөрийн бүтээсэн хоргодох байр /агуй, хавцал, унасан мод, модны хөндий г.м/ олж чадвал та цаг, хүчээ хэмнэж чадна. Хэрэв ийм боломжгүй бол та өөрөө бүгдийг хийнэ. Ийм үед дараах зөвлөгөөг дагаарай.

- Их хүйтэнд түүдэг галгүйгээр та унтаж болохгүй.
- Хүнд нөхцөлд хүчээ гамнаарай.
- Хоргодох байраа гэрэлтэй цагт амжуулан босгоорой.

Байраа аль болох тэгш, нүх, хожуулгүй газарт босгоно. Их том байх нь чухал биш хамгийн гол нь салхи, уснаас хамгаалсан, агаар сэлгэлттэй байх нь чухал. Гарын дор материал ашиглана. Дулааны улиралд овоохой босгох томоохон брезент, даавууг ашиглаж болно. Нэг хүнд 2x0,75 м хэмжээтэй байх нь зохимжтой. Шургааг,мөчир, урт мод зэргийг олно. Хэрэв танд хутга, сүх байхгүй бол хурц иртэй чулуу олж оромж босгоход ашиглана.



Хичээлийг удирдан зохион байгуулах арга, аргачлал, үйл ажиллагааны зөвлөмж:

Үйл ажиллагаа 1: Хичээлийн эхэнд багш скаутын бүлгэмд суралцдаг сурагч байгаа эсэх талаар асууна. Байвал скаут сурагчтай хамтран энэ хичээлийг явуулж болох юм. Эсвэл танай орон нутагт скаутын бүлгэм байдаг бол харилцан бие биенээсээ суралцах боломжтой. Бүлгийн сурагчдыг 2 багт хувааж эхний багт түүдэг гал асаах, 2-р багт цаас ашиглан яага таваг хийх аргуудыг уншаад бусдадаа тайлбарлаж өгөхийг сануулна. 1-р багт чүдэнзний мод ашиглан түүдэг гал бэлтгэхийг, 2-р багт сонин сэтгүүлийн цаас ашиглан аяга, таваг бэлтгэхийг сануулна.

Үйл ажиллагаа 2: Багууд хийсэн ажлуудаараа үзэсгэлэн гаргаж болохоос гадна ханын сонин гаргаж бусадтайгаа энэ мэдлэгээ хуваалцах даалгавар өгөөрэй.

Хичээлийн хэрэглэгдэхүүн: сурах бичиг, том цаас маркер, чүдэнз, сонин, сэтгүүл.





Ашигласан материал

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003
2. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, 2011
3. Галын аюулаас хамгаалах аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566:2005
4. Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын гарын авлага, Хүүхдийг ивээх сан, 2012
5. Аюулгүй амьдрах ухааны үндэс., I, II, III сурах бичиг, 2011
6. НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцийн 15 дугаар зүйлийн гарын авлага, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллага
7. Хүүхдийн оролцоо, Хүүхэдтэй ажилдаг хүн бүрт зориулсан гарын авлага, Хүүхдийг Ивээх Сан, 2010
8. М.Бадарч, Л. Шинэцэцэг., Эко сургууль, Байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжигч байгальд ээлтэй сургуулийн удирдлага, эко зөвлөл, багш, сурагчид, орон нутгийн иргэд, байгаль хамгаалагч, эцэг эхчүүдэд зориулсан сургалтын гарын авлага, 2014
9. О.Үржин нар., Эрэн хайх, аврах ажлын үндэс, 2012
10. Гамшгаас өөрийгөө хамгаалах арга хэмжээний зааварчилгаа, Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь төсөл, 2009
11. “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах” сургалтын гарын авлага, ОБЕГ, Дэлхийн зөн Монгол ОУБ, 2013
12. Гамшиг ослын тухай, Гамшиг судлалын хүрээлэн, 2008
13. Аврагч Мазаалайн зөвлөмж, өрхийн гарын авлага, ОБЕГ, Дэлхийн Зөн Монгол ОУБ, 2014
14. Личная безопасность, Меры предосторожности в повседневной жизни, Поведение в экстремальных ситуациях, Энциклопедия для детей, Москва, 2001
15. 1-2-3 of Disaster Education, European Union, ISDR-UN, Kyoto University, 2013